



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

**ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА
ҮР НӨЛӨӨТЭЙ ОРОЛЦОХ НЬ**



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

**ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА
ҮР НӨЛӨӨТЭЙ ОРОЛЦОХ НЬ**

СУДАЛГААГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН Л.ГАЛБААТАР

ННА 67.3

ДАА 340.009

Г-193

**ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА
ҮР НӨЛӨӨТЭЙ ОРОЛЦОХ НЬ**

Судлаач Л.Галбаатар

© Нээлттэй Нийгэм Форум, 2021

Энэхүү тайланд туссан хөндлөнгийн дүгнэлт, судлаачийн үзэл бодол нь
Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9742-5-1

Мөнхийг үсэг хэвлэлийн компанид хэвлэлийн эхийг бэлтгэж хэвлэв.



АГУУЛГА

09 БҮЛЭГ 1.

Хүний эрхийн үндэсний байгууллага ба иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны талаарх үзэл баримтлал, олон улсын жишиг

27 БҮЛЭГ 2.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаа дахь иргэний нийгмийн байгууллагын оролцоо

62 Дүгнэлт, зөвлөмж

66 Хавсралт

86 Ном зүй

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхэд үнэтэй санал, шүүмж өгч, шаардлагатай эх сурвалжаар хангасан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд, Тамгын газрын дарга, ажилтнууд, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгааны хүрээлэнгийн секторын эрхлэгч Д.Аюуш болон Нээлттэй Нийгэм Форумын Эрх зүйн хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан, ажилтан Д.Ганзул нарт талархал илэрхийлье.





**МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИСС**

УДИРТГАЛ

Хүний эрхийн Үндэсний Комисс нь хүний эрхийг хамгаалах, дэмжих үндсэн чиг үүрэгтэй. Ялангуяа Хүний эрхийн үндэсний байгууллагуудын эрх зүйн байдлын талаарх зарчим буюу Парисын зарчмын дагуу олон талт байдлыг хангах, нийгмийн янз бүрийн бүлгийн хэнийг ч үл орхигдуулахад онцгой анхаарах шаардлагатай. Энэ хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комисс нь тухайн нийгмийн янз бүрийн бүлэгтэй үр дүнтэй хамтран ажиллах процедуртай, тэрхүү процедурын дагуу холбогдох шийдвэр гаргаж ажиллах шаардлагатай.¹


Хүний эрхийн үндэсний байгууллагаас иргэний нийгмийн байгууллагатай харилцах харилцаа нь түүний бие даасан, олон талт байдлыг хамгаалахад тусалдаг болохыг Парисын зарчимд хүлээн зөвшөөрсөн байдаг. Товчхон үгүүлэхэд, Хүний эрхийн үндэсний байгууллагаас тухайн нийгэмд чиглэсэн хамгийн бодит, үр дүнтэй үйл ажиллагааны гол хөшүүрэг нь иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах явдал юм.²

Иргэний нийгмийн байгууллага нь хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцооны гол оролцогч бөгөөд парламент, засгийн газар, шүүх болон хүний эрхийн үндэсний

¹ Global Principles for the Capacity Assessment of National Human Rights Institutions, UNDP, 2016, p.21. <https://nhri.ohchr.org/EN/ExternalPublications/International%20Council%20on%20Human%20Rights%20Policy.aspx>

² Assessing the Effectiveness of National Human Rights Institutions, International Council on Human Rights Policy, 2005, p.15. <https://nhri.ohchr.org/EN/ExternalPublications/International%20Council%20on%20Human%20Rights%20Policy.aspx>

Зураг 1. Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцооны үндсэн оролцогчид



байгууллагатай шууд харилцах, тэр дундаа зөвлөлдөх, хамтран ажиллах гол этгээд билээ.³

Одоогийн болон өмнө хэрэгжиж байсан хууль тогтоомж, зохицуулалтын дагуу иргэний нийгмийн байгууллагаас Комисст чиглэсэн үйл ажиллагааг тодорхойлсон байх бөгөөд Комиссоос иргэний нийгмийн байгууллагад болон харилцан хоорондоо чиглэсэн үйл ажиллагааг орхигдуулсан шинжтэй байна.

Иймд энэхүү судалгаагаар Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 48/134 тоот тогтоолоор баталсан Хүний эрхийн үндэсний байгууллагуудын эрх зүйн байдлын талаарх зарчим буюу Парисын зарчмын үзэл санаа, агуулгын дагуу Хүний эрхийн Үндэсний Комисс ба иргэний нийгмийн байгууллага хоорондын бодитой, үр дүнтэй, олон талт үйл ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж гаргахыг зорилоо.

³ UNDP-OHCHR Toolkit for collaboration with National Human Rights Institutions, December 2010, p.4, 36, <https://nhri.ohchr.org/EN/ExternalPublications/OHCHR-%20UNDP-Toolkit.aspx>



БҮЛЭГ 1

Хүний эрхийн үндэсний байгууллага ба иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны талаарх үзэл баримтлал, олон улсын жишиг



1.1.	Олон улсын жишиг	10
1.1.1.	НҮБ дахь төрийн бус байгууллагын зөвлөлдөх статус	10
1.1.2.	Хүний эрхийг хамгаалах, дэмжих талаарх олон улсын зарчим, зөвлөмжид хүний эрхийн үндэсний байгууллага ба төрийн бус байгууллага хоорондын харилцааг тодорхойлсон байдал	14
1.2.	Бусад улсын туршлага	15
1.2.1.	Азийн зарим улсын туршлага	16
1.2.2.	Европын зарим улсын туршлага	18
1.2.3.	Хамтын нөхөрлөлийн зарим улсын туршлага	22

1.1. Олон улсын жишиг

1.1.1. НҮБ дахь төрийн бус байгууллагын зөвлөлдөх статус

НҮБ байгуулагдсан цагаас буюу 1945 оноос төрийн бус байгууллагууд НҮБ-тай идэвхтэй харилцаатай байна. Тодруулбал, НҮБ-ын Дүрмийн 71 дүгээр зүйлд “Эдийн засаг, нийгмийн зөвлөл түүний эрх хэмжээний хүрээний тодорхой асуудлыг сонирхож байгаа засгийн газрын бус байгууллагуудтай зөвлөлдөх талаар зохих арга хэмжээ авах эрхтэй...” гэж заасан.⁴

НҮБ-ын Дүрмийн 61 дүгээр зүйлд зааснаар “Эдийн засаг, нийгмийн зөвлөл нь Ерөнхий Ассамблейгаас сонгосон НҮБ-ын тавин дөрвөн гишүүнээс бүрэлдэнэ”, 62 дугаар зүйлд зааснаар “Эдийн засаг, нийгмийн зөвлөл олон улсын эдийн засаг, нийгэм, соёл, боловсрол, эрүүл мэнд болон тэдгээртэй холбогдох асуудлаар судалгаа хийх, тайлан боловсруулах буюу санаачлах, түүнчлэн эдгээр аль ч асуудлын хүрээнд Ерөнхий Ассамблей, НҮБ-ын гишүүн улс болон холбогдох төрөлжсөн байгууллагад зөвлөмж гаргах эрхтэй”.

Эдийн засаг, нийгмийн зөвлөл (ЭЗНЗ) нь хүний эрх, хэн бүхний үндсэн эрх чөлөөг хүндэтгэн сахих явдлыг дэмжих зорилгоор зөвлөмж гаргадаг. Мөн өөрийн эрх хэмжээний асуудлаар конвенцын төсөл бэлтгэж Ерөнхий Ассамблейд оруулах, НҮБ-аас тогтоосон журмын дагуу олон улсын хурал чуулганыг зарлан хуралдуулах эрхтэй.

Дээрх зохицуулалтын дагуу НҮБ-ын ЭЗНЗ-өөс төрийн бус байгууллагуудтай зөвлөлдөх харилцааг тус зөвлөлийн 1996 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 49 дүгээр чуулганы хуралдааны “НҮБ болон төрийн бус байгууллагууд хоорондын зөвлөлдөх харилцааны тухай” 1996/31 тоот тогтоолоор зохицуулсан.⁵ Тус тогтоолын 1 дэх хэсэгт “Зөвлөлдөх харилцааг тогтооход хэрэглэх зарчим”-ыг 1-17, 2 дахь хэсэгт “Зөвлөлдөх үйл ажиллагааг зохион байгуулахад баримтлах зарчим”-ыг 18-20, 3 дахь хэсэгт “Зөвлөлдөх харилцаа тогтоох” талаар 21-26,

⁴ Монгол Улсын олон улсын гэрээ, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм, 1945 оны 6 дугаар сарын 26-ны өдөр баталж, 1945 оны 10 дугаар сарын 24-ний өдөр хүчин төгөлдөр болсон. <https://www.legalinfo.mn/law/details/1211?lawid=1211>

⁵ The Economic and Social Council, UN Resolution 1996/31, Consultative relationship between the United Nations and non-governmental organizations, 49th plenary meeting, 25 July, 1996. https://www.unov.org/documents/NGO/NGO_Resolution_1996_31.pdf

4 дэх хэсэгт “Зөвлөлтэй зөвлөлдөх” талаар 27-32, 5 дахь хэсэгт “Зөвлөлийн комисс болон бусад туслах байгууллагатай зөвлөлдөх” талаар 33-39, 6 дахь хэсэгт “Зөвлөлийн түр хороотой зөвлөлдөх” талаар 40, 7 дахь хэсэгт “НҮБ-аас зарласан олон улсын хурлууд, тэдгээрийг бэлтгэх үйл явц дахь төрийн бус байгууллагуудын оролцоо”-ны талаар 41-54, 8 дахь хэсэгт “Зөвлөлдөх статусыг түдгэлзүүлэх, хасах” талаар 55-59, 9 дэх хэсэгт “Төрийн бус байгууллагууд хариуцсан Зөвлөлийн хороо”-ны талаар 60-63, 10 дахь хэсэгт “Нарийн бичгийн даргын газартай зөвлөлдөх” талаар 64-67, 11 дэх хэсэгт “Нарийн бичгийн даргын газрын дэмжлэг”-ийн талаар 68-70 дахь заалтаар тус тус зохицуулжээ.

НҮБ-ын ЭЗНЗ-д зөвлөлдөх статустай нийт 5,593 төрийн бус байгууллага байх бөгөөд үүнээс 137 нь ерөнхий асуудлаар; 4,488 нь тусгай асуудлаар; үлдсэн нь бусад асуудлаар зөвлөлдөх статустай байна.⁶ Тухайлбал, хүний эрхийн олон улсын байгууллага болох “Эмнести Интернэшнл” 1964 оноос НҮБ-ын ЭЗНЗ-д тусгай асуудлаар зөвлөлдөх статустай болсон.

НҮБ-ын ЭЗНЗ-ийн хувьд төрийн бус байгууллагуудаас шинжээчийн үнэ цэнтэй зөвлөгөө авах боломжтой төдийгүй төрийн бус байгууллагууд ч байр сууриа илэрхийлэх, ЭЗНЗ-ийн ажилд нөлөөлөх боломжтой. Тухайн асуудлаар мэргэшсэн, ур чадвартай, дадлага туршлагатай, үр нөлөөтэй төрийн бус байгууллагууд НҮБ-ын үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлдэг.

НҮБ-д зөвлөлдөх статустай төрийн бус байгууллагуудын хувьд:

- Тухайн салбарт хуримтлуулсан туршлагадаа тулгуурлан тодорхой асуудлаар шинжээчийн дүн шинжилгээ хийх;
- Урьдчилан сэрэмжлүүлэх мэргэжилтний үүрэг гүйцэтгэх;
- Олон улсын баримт бичгүүдэд мониторинг хийх, хэрэгжүүлэхэд туслах;
- Тухайн асуудлаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхэд туслах;
- НҮБ-ын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэх;
- Зохион байгуулалтын арга хэмжээнд шаардлагатай мэдээллээр хувь нэмэр оруулах үүрэгтэй ажиллана.

Харин ЭЗНЗ-ийн хувьд төрийн бус байгууллагуудыг дэлхий дахинд дуу хоолойгоо бодитоор хүргэх, хэлэлцэх асуудалд хувь нэмрээ оруулах боломжоор хангах үүрэгтэй. Зөвлөлдөх статустай төрийн бус байгууллагын хувьд:

⁶ Consultative Status with ECOSOC and other accreditations
<https://esango.un.org/civilsociety/displayConsultativeStatusSearch.do?method=search&sessionCheck=false>

- Олон улсын хурал, арга хэмжээнд оролцох;
- Тэдгээр арга хэмжээнд бичгээр болон амаар мэдэгдэл хийх;
- Нэмэлт арга хэмжээ зохион байгуулах;
- НҮБ-ын байранд нэвтрэх;
- Бусадтай харилцах, мэдээлэл солилцох болон лобби хийх боломжтой байх нөхцөлтэй.


НҮБ-ын ЭЗНЗ нь түүний түншлэгч аливаа байгууллагад ямар нэгэн санхүүжилт олгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх ёсгүй. Хэдий тийм боловч ЭЗНЗ-ийн үйл ажиллагаатай холбогдох олон нийтийн арга хэмжээ нь байгууллагуудад өөрсдийн харилцаа холбоо, мэдлэгээ өргөжүүлэх, янз бүрийн оролцогч талтай хамтран ажиллах түншлэл тогтоох, хамтарсан төсөл судлах боломж олгодог.⁷

НҮБ-ын ЭЗНЗ-ийн зөвлөлдөх статустай төрийн бус байгууллага болоход тавигддаг шаардлагыг жагсаавал:

- Төрийн бус байгууллагын үйл ажиллагаа нь Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн үйл ажиллагаатай хамааралтай байх;
- Ил тод, ардчилсан шийдвэр гаргах механизмтай, ардчилсан замаар баталсан дүрэмтэй байх;
- Гүйцэтгэх ажилтан бүхий удирдах төвтэй байх;
- Өргөдөл гаргах үед хоёроос доошгүй жил ажилласан байх;
- Гишүүдийнхээ төлөө үг хэлэх эрх мэдэлтэй байх;
- Төлөөллийн бүтэцтэй байх;
- Хариуцлагын зохих механизмтай байх;
- Шууд болон шууд бус хэлбэрийн шимтгэл, бусад дэмжлэг, зардлыг багтаасан санхүүгийн тайланг Хороонд өгөх.

⁷ United Nations, Working with ECOSOC - A NGOs Guide to an Consultative Status, New York, 2018, p.17, http://csonet.org/content/documents/ECOSOC%20Brochure_2018_Web.pdf

Зураг 2. НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн зөвлөлдөх статустай төрийн бус байгууллага болох зургаан алхам



Зөвлөлдөх статус бүхий төрийн бус байгууллага тайлангаа дөрвөн жил тутамд цахим системээр дамжуулан гаргана. Тайлан гаргах хугацаанаас зургаан сарын өмнө ЭЗНЗ-ийн Төрийн бус байгууллагын салбараас энэ талаар мэдээлж, сануулах бөгөөд тийнхүү тайлан гаргаагүйн үр дагаврыг мэдэгдэнэ. Хэрэв тайлангаа хугацаанд нь гаргаагүй бол дараах үр дагавар үүснэ. Үүнд:

- Тайлан гаргах хугацаа хэтэрснээс хойш нэг сарын дараа Төрийн бус байгууллагын салбараас тайлангаа дараа оны 1 дүгээр сарын 1 гэхэд гаргахыг хүссэн мэдэгдэл илгээнэ.
- Хэрэв тухайн хугацаанд тайлангаа гаргаагүй бол Төрийн бус байгууллагын салбараас тухайн оны 5 дугаар сарын 1 гэхэд тайлангаа гаргахыг хүссэн эцсийн мэдэгдлийг илгээнэ. Ийнхүү заасан хугацаанд тайлангаа гаргаагүй бол Төрийн бус байгууллагууд хариуцсан Зөвлөлийн хорооноос тэр даруй тухайн байгууллагын зөвлөлдөх статусыг нэг жилийн хугацаагаар түдгэлзүүлэх тухай зөвлөмж гаргана.

- Хэрэв ЭЗНЗ-өөс зөвлөлдөх статусыг түдгэлзүүлэх шийдвэр гаргавал энэ тухай болон тайланг дараа оны 5 дугаар сарын 1 гэхэд гаргах талаар мэдэгдэнэ.
- Хэрэв тухайн мэдэгдсэн хугацаанд тайлангаа гаргаагүй бол зөвлөлдөх статусыг хасах тухай Төрийн бус байгууллагууд хариуцсан Зөвлөлийн хорооноос зөвлөмж гаргана.⁸

1.1.2. Хүний эрхийг хамгаалах, дэмжих талаарх олон улсын зарчим, зөвлөмжид хүний эрхийн үндэсний байгууллага ба төрийн бус байгууллага хоорондын харилцааг тодорхойлсон байдал

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 48/134 тоот тогтоолоор баталсан Хүний эрхийн үндэсний байгууллагуудын эрх зүйн байдлын талаарх зарчим буюу Парисын зарчмын 1(а)-д “Хүний эрхийн үндэсний байгууллагын бүрэлдэхүүнд иргэний нийгмийн олон талт төлөөллийг оролцуулах баталгааг хангах; Хүний эрхийн үндэсний байгууллага нь хүний эрхийг дэмжих, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай харилцаа холбоо хөгжүүлэх шаардлагатай” талаар заасан.⁹

Энэ нь хүний эрхийг хамгаалах, дэмжих гол оролцогч нь иргэний нийгмийн байгууллага болохыг онцгой анхаарч түүнтэй нягт, идэвхтэй хамтран ажиллахыг илэрхийлж байгаа бөгөөд зөвхөн Комиссын үйл ажиллагаанд дэмжлэг авах бус харилцан дэмжлэг үзүүлэх нь чухал болохыг илэрхийлсэн хэрэг юм.

Мөн НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд 2018 оны 8 дугаар сарын 14-ний өдөр, НҮБ-ын Ерөнхий Ассамблейд 2019 оны 7 дугаар сарын 25-ны өдөр тус тус танилцуулсан “Хүний эрхийг хамгаалах, дэмжих үндэсний байгууллагууд” тайландаа “Хүний эрхийн үндэсний байгууллагууд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлж, түүнийгээ албан ёсны болгон хадгалж, хүний эрхийг сурталчлах, хамгаалах чадавхыг бэхжүүлэх шаардлагатай” болохыг зөвлөжээ.¹⁰ Түүнчлэн, НҮБ-ын Ерөнхий Ассамблейд 2020 оны 7 дугаар сарын 20-ны өдөр танилцуулсан “Хүний эрхийг

⁸ ECOCOC resolution 2008/4 on "Measures to improve the quadrennial reporting procedures." <https://www.un.org/ecosoc/sites/www.un.org/ecosoc/files/documents/2008/resolution-2008-4.pdf>

⁹ Principles relating to the Status of National Institutions (The Paris Principles). Adopted by General Assembly resolution 48/134 of 20 December 1993 <https://nhri.ohchr.org/EN/AboutUs/Pages/ParisPrinciples.aspx>

¹⁰ Secretary-General's report to the Human Rights Council on national institutions for the promotion and protection of human rights: A/HRC/39/20 <https://undocs.org/A/HRC/39/20>
Secretary-General's report to the General Assembly on national institutions for the promotion and protection of human rights: A/74/226 <https://undocs.org/A/74/226>


хамгаалах, дэмжихэд омбудсмен, зуучлагч, хүний эрхийн бусад институтийн үүрэг” тайландаа “29. Омбудсмен, зуучлагч, хүний эрхийн бусад институтийн зүгээс төрийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэх, бэхжүүлэх шаардлагатай” болохыг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга онцолсон байна.¹¹

1.2. Бусад улсын туршлага

1993 онд Тунист болсон олон улсын хурлаар хүний эрхийн үндэсний байгууллагууд “Хүний эрхийн байгууллагуудын сүлжээний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах олон улсын хороо” байгуулсан бөгөөд 2016 онд тус хорооны нэрийг “Хүний эрхийн үндэсний байгууллагуудын олон улсын холбоо” болгож өөрчилсөн. Тус холбоо нь Швейцарын хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд бөгөөд Гүйцэтгэх товчоо нь тус холбооны гишүүн, дөрвөн бүс нутгийн төлөөлөл болох “А статус” бүхий хүний эрхийн үндэсний 16 байгууллагаас бүрдэнэ. 2021 оны байдлаар Хүний эрхийн үндэсний байгууллагуудын олон улсын холбоо нь 117 гишүүнтэй бөгөөд үүнээс 84 нь Парисын зарчмыг бүрэн хангасан буюу “А статус”-тай, 33 нь Парисын зарчмыг хэсэгчлэн хангасан буюу “Б статус”-тай байна.¹²

Иймд Хүний эрхийн үндэсний байгууллагуудын олон улсын холбооноос Парисын зарчмыг бүрэн хангасан буюу “А статус”-тай гэж тогтоосон улсыг сонгон авч, тухайн улсын хүний эрхийн үндэсний байгууллага нь төрийн бус байгууллагатай хэрхэн хамтран ажилладаг туршлагыг судаллаа.

Зураг 3. Хүний эрхийн үндэсний байгууллагууд Парисын зарчмыг хангасан байдал



¹¹ Secretary-General's report to the General Assembly on the role of the Ombudsman, mediator and other national human rights institutions in the promotion and protection of human rights, A/75/224 <https://undocs.org/A/75/224>

¹² Global Alliance of National Human Rights Institutions (GANHRI), Members <https://ganhri.org/membership/>

1.2.1. Азийн зарим улсын туршлага

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд 2018 оны 8 дугаар сарын 14, НҮБ-ын Ерөнхий Ассамблейд 2019 оны 7 дугаар сарын 25-ны өдөр тус тус танилцуулсан “Хүний эрхийг хамгаалах, дэмжих үндэсний байгууллагууд” тайландаа Ази, Номхон далайн бүс нутагт Камбож, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бангладеш, Папуа Шинэ Гвиней, Филиппин, Шри Ланка, Зүүн Тимор, Афганистан дахь хүний эрхийн үндэсний байгууллага болон иргэний нийгмийн байгууллага хоорондын харилцааг бэхжүүлэх ажил амжилттай болсныг дурдсан.¹³

Шри Ланка Улсын Хүний эрхийн комисс 2016 онд иргэний нийгмийн байгууллагуудтай хэлэлцүүлэг хийх, харилцах зохих суваг бий болгожээ.¹⁴ Тодруулбал, Шри Ланка Улсын Хүний эрхийн комисс хүний эрхийн тодорхой асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор сэдэвчилсэн есөн дэд хороо байгуулсан байна. Эдгээр дэд хороонд:

- Цагаач ажилчдын эрхийн дэд хороо;
- Өөр өөр чадвартай хүмүүсийн эрхийн дэд хороо;
- Боловсролын бодлогын дэд хороо;
- Ахмадын эрхийн дэд хороо;
- Жендерийн асуудлаарх дэд хороо;
- Саатуулах, баривчлахтай холбоотой зөрчлийн дэд хороо;
- Тариалангийн ажилчдын эрхийн дэд хороо;
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн дэд хороо;
- ЛГБТ хүмүүсийн эрхийн дэд хороо багтжээ.

Эдгээр дэд хорооны гишүүд нь иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид, хүний эрхийн идэвхтэн, судлаачид юм. Түүнчлэн, Шри Ланка Улсын Хүний эрхийн комиссын орон нутгийн салбар нь иргэний нийгмийн сүлжээ бий болгосон. Дэд хороод болон иргэний нийгмийн сүлжээ нь сар бүр Засгийн газрын зохицуулах хороотой уулздаг тул иргэний нийгмийн байгууллага, Хүний эрхийн комиссын хамтын үйл ажиллагаа нь олон талт үзэл бодол, дуу хоолойг хүргэх форум болдог. Эдгээр дэд хороог Хүний эрхийн комиссын гишүүд даргалах бөгөөд дэд хороод хариуцсан чиглэлээрх хууль тогтоомж, бодлого, бусад баримт

¹³ Secretary-General's report to the Human Rights Council on national institutions for the promotion and protection of human rights, A/HRC/39/20 <https://undocs.org/A/HRC/39/20>

¹⁴ Law and Society Trust (LST), "Sri Lanka: Reviving Amid Challenges", *Ibid*, p.162.

бичгийг хянаж, түүнийг өөрчлүүлэх асуудлаар Комисст зөвлөмж өгөх, тухайн чиглэлээрх хүний эрхийн олон улсын механизмд Комиссоос төлөөллөө илгээх, тайлагнах явцад Комисст зөвлөгөө өгөх нөхцөлтэй.¹⁵

БНСУ-ын 2001 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1-д “Комисс нь ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай асуудлаар зөвлөгөө авах зорилгоор зөвлөх байгууллагатай байж болно”, 2-т “Зөвлөх байгууллагыг зохион байгуулах, ажиллуулахад шаардлагатай асуудлыг Комиссын дүрмээр тогтооно” гэж тус тус заасан.¹⁶ Үүний дагуу хүний эрхийн шинжээчид, хүний эрх хамгаалагчдаас бодлогын зөвлөгөө авах, туслалцаа авах буюу иргэний нийгэмтэй хамтран ажиллахад туслах суваг болгон Бодлогын зөвлөх хороо болон Шинжээчийн хороог байгуулсан.¹⁷ БНСУ-ын Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Олон улсын хүний эрхийн механизмын талаарх Зөвлөх хорооны үйл ажиллагааг Комиссын цахим хуудсанд мэдээлдэг бөгөөд тус хороо 2020 оны хурлаараа НҮБ-ын Хүний эрхийн хороонд илгээх тус улсын тав дахь тайлангийн төслийн талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын байр суурь, дүгнэлтийг хянан шинжилж хэлэлцжээ. Зөвлөх хорооны гишүүд НҮБ-ын Хүний эрхийн хороонд өгөх Засгийн газрын тайланд буй баримтуудыг тодруулах, Хүний эрхийн Үндэсний Комиссын байр суурийг илүү идэвхтэй танилцуулах шаардлагатай болохыг онцолжээ. Ялангуяа Хүний эрхийн үндэсний байгууллагын тайлангийн ач холбогдол нэмэгдэж байгааг харгалзан Хүний эрхийн Үндэсний Комиссоос НҮБ-ын Хүний эрхийн хороонд өгөх бие даасан тайландаа холбогдох сэдвүүдийг нарийвчлан судалж, тусгах шаардлагатай гэж үзжээ. Мөн Комиссоос зохион байгуулах олон улсын хурлын хэлэлцэх асуудалд цар тахлын үеийн ялгаварлан гадуурхалттай холбоотой сэдвийг зайлшгүй хөндөх, тусгах шаардлагатай болохыг Зөвлөх хорооноос зөвлөсөн байна. БНСУ-ын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Зөвлөх хорооны байр суурь, дүгнэлтийг харгалзан үзэхээ мэдэгджээ. Зөвлөх хороо нь 11 гишүүнтэй бөгөөд Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, НҮБ-ын Хүний эрхийн гэрээний байгууллагын шинжээчид, олон улсын эрх зүйн профессорууд, төрийн бус байгууллагаас бүрддэг.¹⁸

¹⁵ Human Rights Commission of Sri Lanka - Thematic Sub Committees <https://www.hrcsl.lk/about/thematic-sub-committees/>

¹⁶ National Human Rights Commission of Korea. National Human Rights Commission Act <https://www.humanrights.go.kr/site/homepage/menu/viewMenu?menuid=002003001002>

¹⁷ Response – OHCHR – NHRCK https://www.ohchr.org/Documents/Issues/IntLaw/PreventionStudy/NHRI/National_Human_Rights_Commission_Korea.pdf

¹⁸ NHRCK’s Advisory Committee on International Human Rights Mechanism Holds its First Meeting of 2020 <https://www.humanrights.go.kr/site/program/board/basicboard/view?menuid=002002005&boardtypeid=7013&boardid=7605443>

1.2.2. Европын зарим улсын туршлага

Европын Зөвлөлийн Сайд нарын хорооноос 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр баталсан “Хүний эрхийн үндэсний байгууллагуудын бие даасан, олон талт, үр нөлөөтэй байдлыг хөгжүүлэх, бэхжүүлэх талаар гишүүн орнуудад өгсөн зөвлөмж”-д “Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь хүний эрхийн хамгаалагч бөгөөд хүний эрхийн бусад хамгаалагчийг хамгаалах, дэмжих болон аюулгүй, тухтай иргэний нийгмийн орон зай бий болгоход хувь нэмрээ оруулах; хүний эрхийн үндэсний байгууллагуудын үр нөлөөтэй үйл ажиллагаа нь төр болон иргэний нийгмийн хооронд чухал холбоос болж, хувь хүний эрхийг хамгаалах төрийн үүрэг хариуцлагын цоорхойг нөхөхөд туслалцаа үзүүлэх бөгөөд иргэний нийгмийн оролцогч талууд, ялангуяа төрийн бус байгууллагууд, хүний эрхийн хамгаалагчид нь хүний эрхийн үндэсний байгууллагуудын үйл ажиллагааны нэг хэсэг болох, түүнтэй хялбар, аюулгүй харилцах боломж олгох хэрэгтэй” гэжээ.¹⁹

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд 2018 оны 8 дугаар сарын 14, НҮБ-ын Ерөнхий Ассамблейд 2019 оны 7 дугаар сарын 25-ны өдөр тус тус танилцуулсан “Хүний эрхийг хамгаалах, дэмжих үндэсний байгууллагууд” тайландаа Европ, Төв Азийн бүс нутагт Украин, Өмнөд Кавказ, хуучин Югославын Бүгд Найрамдах Македон Улс, Серб, Бүгд Найрамдах Молдав Улс, ОХУ, Косово дахь хүний эрхийн үндэсний байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллага хоорондын харилцааг бэхжүүлэх ажил амжилттай болсон талаар дурджээ.²⁰

ОХУ-ын Хүний эрхийн дээд комиссарын дэргэд хүний болон иргэний эрх, эрх чөлөөний чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдээс бүрдсэн Шинжээчдийн зөвлөл ажиллах бөгөөд Дээд комиссарт зөвлөлдөх дэмжлэг үзүүлдэг.²¹ Тодруулбал, 1997 оны 2 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан ОХУ-ын Хүний эрхийн дээд комиссарын тухай хуулийн 41 дүгээр зүйлд “Хүний эрхийн дээд комиссарт зөвлөх зорилго бүхий хүний болон иргэний эрх, эрх чөлөөний асуудлаар мэргэшсэн хүмүүсээс бүрдсэн шинжээчдийн зөвлөлийг Хүний

¹⁹ Recommendation CM/Rec(2021)1 of the Committee of Ministers to member States on the development and strengthening of effective, pluralist and independent national human rights institutions (Adopted by the Committee of Ministers on 31 March 2021 at the 1400th meeting of the Ministers' Deputies) https://search.coe.int/cm/pages/result_details.aspx?ObjectId=0900001680a1f4da

²⁰ Secretary-General's report to the Human Rights Council on national institutions for the promotion and protection of human rights, A/HRC/39/20 <https://undocs.org/A/HRC/39/20>

²¹ High Commissioner for Human Rights in the Russian Federation - Expert Council https://eng.ombudsmanrf.org/ombudsman/content/expert_council

эрхийн дээд комиссарын дэргэд байгуулж болно” гэж заасан.²² Үүний дагуу ОХУ-ын засаг захиргааны холбогдох нэгж тус бүрт хүний эрх, эрх чөлөөний Шинжээчдийн зөвлөл ажиллаж байна.

Тухайлбал, Москва дахь Хүний эрхийн комиссарын дэргэдэх Шинжээчийн зөвлөл нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах мэдлэг, туршлага бүхий олон нийт, хүний эрх, боловсрол, анагаах ухаан, соёлын болон бусад байгууллагыг төлөөлсөн 15-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй.²³ Тус зөвлөлийн бүрэлдэхүүнийг Комиссар батлах бөгөөд зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа нь Комиссарын бүрэн эрхийн хугацаатай адил байдаг. Зөвлөлийн гишүүд нь үйл ажиллагаагаа үнэ төлбөргүй хэрэгжүүлэх бөгөөд дараах үйл ажиллагаа явуулна. Үүнд:

- Комиссарын үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах санал бэлтгэх;
- Москва хот дахь хууль сахиулах байгууллагаас хүний эрх, эрх чөлөөг хэрхэн хангаж буй талаар Комиссарын газраас танилцуулсан баримт бичигт цогц дүн шинжилгээ хийх;
- Москва хотод мөрдөж буй хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой эрх зүйн тодорхой актын талаар дүгнэлт боловсруулах;
- Хүний эрхийн асуудлаарх одоогийн хууль тогтоомжийг нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ болон ОХУ-ын Үндсэн хуульд нийцүүлэн боловсронгуй болгох талаарх саналыг Комиссарт гаргах;
- Комиссарын жил тутмын тайлан, дүн шинжилгээний бусад материалыг бэлтгэхэд туслалцаа үзүүлэх;
- Комиссарын үйл ажиллагаанд шинжлэх ухааны, эрх зүйн болон мэдээллийн дэмжлэг үзүүлэхтэй холбоотой асуудлыг судлах;
- Комиссарын хүсэлтийн дагуу иргэдээс төрийн болон орон нутгийн байгууллага, албан тушаалтны талаар гаргасан гомдолд дүгнэлт бэлтгэх;
- Бүс нутгийн түвшинд хүний эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааны талаарх ОХУ-ын болон олон улсын туршлагыг судлах;
- Бүх нийтэд эрх зүйн боловсрол олгох үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх;
- Комиссарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бусад үйл ажиллагаа.

Шинжээчийн зөвлөлийн бүх шийдвэр нь зөвлөх, зөвлөмж өгөх шинжтэй байх

²² Федеральный конституционный закон от 26 февраля 1997 года №1-ФКЗ, «Об Уполномоченном по правам человека в Российской Федерации» <https://ombudsmanrf.org/upload/files/docs/npa/4.rtf>

²³ Приложение №1 к распоряжению Уполномоченного по правам человека в городе Москве от 14 ноября 2014 года, №52 http://ombudsman.mos.ru/download.php?model=document&record_id=39

бөгөөд зөвлөмж, дүгнэлт, санал, тайлбар, дүн шинжилгээ хэлбэртэй байна. Зөвлөлийн үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг түүний санал болгосны дагуу Комиссар батална. Зөвлөл нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд Зөвлөлийн даргыг Комиссар томилно. Зөвлөлийн ээлжит хурал улиралд нэгээс доошгүй удаа болох бөгөөд Зөвлөлийн дарга нь Зөвлөлийн хурлын тов, хэлэлцэх асуудлыг тогтоох зэргээр Зөвлөлийн үйл ажиллагааны ерөнхий удирдлагыг хэрэгжүүлдэг.

Бүгд Найрамдах Австри Улсын омбудсмэний зөвлөлийн тухай 1982 оны хуулийн 14-т Хүний эрхийн зөвлөх зөвлөл нь Бүгд Найрамдах Австри Улсын омбудсмэний зөвлөлд хүний эрхийг хамгаалах, дэмжих асуудлаар зөвлөх бөгөөд ялангуяа төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх ерөнхий тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, үйл ажиллагаанд нь зөвлөх чиг үүрэгтэй байна. Мөн Хүний эрхийн зөвлөх зөвлөл нь Бүгд Найрамдах Австри Улсын омбудсмэний зөвлөлийн үйл ажиллагааны журам, хяналт шинжилгээний стандартыг хэрхэн хангаж буйтай холбоотой санал гаргаж болно.²⁴ Хүний эрхийн үндэсний байгууллагуудын олон улсын холбооноос Бүгд Найрамдах Австри Улсын омбудсмэний зөвлөлийг Парисын зарчмыг хэсэгчлэн хангасан буюу “Б статус”-тай гэж тогтоожээ. Үүнд Бүгд Найрамдах Австри Улсын омбудсмэний зөвлөл иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах механизмыг зохих ёсоор бүрдүүлээгүй нь нөлөөлсөн байна. Үүнтэй холбоотойгоор Бүгд Найрамдах Австри Улсын омбудсмэний зөвлөл 2012 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Хүний эрхийн зөвлөлдөх зөвлөлийг байгуулан ажиллуулж байна.

Бүгд Найрамдах Австри Улсын омбудсмэний зөвлөлийн тухай 1982 оны хуулийн 15-д зааснаар Хүний эрхийн зөвлөх зөвлөл нь дарга, орлогч, 14 гишүүн, 14 орлогч гишүүний бүрэлдэхүүнтэй. Үүнээс долоо нь төрийн бус байгууллагын төлөөлөл, үлдсэн нь холбооны сайд нарын болон орон нутгийн төлөөлөл байна. Тус зөвлөлийн гишүүдийг сайд нар болон төрийн бус байгууллагууд нэр дэвшүүлж санал болгосноор Бүгд Найрамдах Австри Улсын омбудсмэний зөвлөлөөс томилдог. Зөвхөн хүний эрхийн салбарт мэдлэг, туршлагатай хүнийг зөвлөлийн гишүүнээр томилох бөгөөд Омбудсмэний зөвлөл нь Хүний эрхийн зөвлөлдөх зөвлөлд жендерийн тэнцвэртэй төлөөлөл, угсаатны бүлэг, цөөнхийн зохих төлөөллийг оруулах, түүнчлэн Хүний эрхийн зөвлөх зөвлөлийн хараат

²⁴ The Federal Law on the Austrian Ombudsman Board (Volksanwaltschaftsgesetz 1982 - VolksanwG), https://volksanwaltschaft.gv.at/downloads/974v3/AOB_Ombudsman_Act.pdf

бус, олон ургалч бүтэц бий болгохыг эрмэлзэх шаардлагатай.²⁵ Хүний эрхийн зөвлөлдөх зөвлөл нь Омбудсмэний зөвлөлийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох үйл явцад оролцох буюу саналаа илэрхийлэх эрхтэй. Хүний эрхийн зөвлөлдөх зөвлөл дэх төрийн бус байгууллагуудын төлөөлөлд Австри дахь “Эмнести интернэшл” зэрэг байгууллагын төлөөлөл ажиллаж байна.

Бүгд Найрамдах Эстони Улсын Хууль зүйн канцлерын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан нь 2019 оноос эхлэн үйлчилж байна. Үүний дагуу Эстонид Хууль зүйн канцлерыг хүний эрхийн үндэсний байгууллага гэж хүлээн зөвшөөрсөн бөгөөд хүний эрхийг хамгаалах, сурталчлах чиглэлээр Хууль зүйн канцлерт ногдсон нэмэлт үүрэг нь түүний эрх зүйн байдлыг бэхжүүлсэн.²⁶ Эдгээр ажлыг илүү үр дүнтэй, хүртээмжтэй хэрэгжүүлэхийн тулд Хууль зүйн канцлер 2019 оны эхээр хүний эрхийн асуудлаарх зөвлөх хороо байгуулжээ. Хүний эрхийн асуудлаарх зөвлөх хорооны зорилго нь Хууль зүйн канцлерт хүний эрхийг хамгаалах, сурталчлах, хүний эрхийн нөхцөл байдалд хяналт тавихад нь зөвлөгөө өгөх явдал юм.²⁷ Хүний эрхийн асуудлаарх зөвлөх хороо нь дараах чиглэлээр Хууль зүйн канцлерт зөвлөх үүрэгтэй. Үүнд:

- хүний эрхийг хамгаалах үүднээс нөхцөл байдлыг тодорхойлох;
- хүний эрхтэй холбоотой асуудал дэвшүүлж, тэдгээрийг шийдвэрлэх гарц эрэлхийлэх;
- хүний эрхийн судалгааны эрэлт хэрэгцээг тодорхойлох, зохион байгуулах;
- хүний эрхийн боловсрол түгээх;
- оролцогч талуудын хоорондох мэдээллийн солилцоог сайжруулах.

Зөвлөх хорооны гишүүдийг Хууль зүйн канцлерын байгуулсан хорооноос нээлттэй өрсөлдөөний журмаар сонгодог. Канцлерын байгуулсан хороо нь Зөвлөх хорооны гишүүдийг сонгохдоо ижил тэгш хандах, олон талт байдал, тэнцвэрт байдлын зарчмуудыг удирдлага болгоно. Хууль зүйн канцлер шаардлагатай бол Зөвлөх хороонд тэдгээрийн зөвшөөрлийн үндсэн дээр шинэ гишүүн урьж болно. Зөвлөх хорооны гишүүнчлэл, оролцоо нь сайн дурын үндсэн

²⁵ Austrian Ombudsman Board - The Human Rights Advisory Council, <https://volksanwaltschaft.gv.at/en/preventive-human-rights-monitoring/human-rights-advisory-council#anchor-index-2480>

²⁶ The Chancellor of Justice received the highest international recognition, <https://www.oiguskantsler.ee/en/chancellor-justice-received-highest-international-recognition>

²⁷ Advisory Committee on Human Rights, <https://www.oiguskantsler.ee/en/advisory-committee-human-rights>

дээр явагддаг. Зөвлөх хороог дөрвөн жилийн хугацаатай сонгодог бөгөөд жилд хоёроос доошгүй удаа хуралдана. Зөвлөх хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Хууль зүйн канцлераар ахлуулсан хурал юм. Зөвлөгөө авахын тулд Хууль зүйн канцлер Зөвлөх хорооны гишүүнд шууд хандах, эсвэл тухайн асуудлаар ажлын хэсэг байгуулж болдог. Зөвлөх хорооны гишүүдийн санал, зөвлөмжийг Хууль зүйн канцлер заавал биелүүлэх үүрэггүй.

Зөвлөх хорооны 50 гишүүнийг нээлттэй өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, Эстони Улсын өнцөг булан бүрээс нийгмийн хамгаалал, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, боловсрол, судалгаа, эрүүл мэндийн үйлчилгээ, генетикийн инженерчлэл, анагаах ухааны ёс зүй, архитектур, хөдөлмөрийн эрх зүй, хувийн өгөгдөл, угсаатны зүй ба хэл шинжлэл, шашны эрх чөлөө, байгаль орчны хамгааллын чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдээс бүрдүүлдэг.

1.2.3. Хамтын нөхөрлөлийн зарим улсын туршлага

Хамтын нөхөрлөлийн орнуудад Африк, Ази, Америк, Европ, Номхон далайн нийт 54 орон багтах бөгөөд дэлхийн хамгийн том, хамгийн жижиг, хамгийн баян болон ядуу орнууд байдаг.²⁸

²⁸ 54 countries in the Commonwealth, <https://thecommonwealth.org/member-countries>

Хүснэгт 1. Хамтын нөхөрлөлийн орнууд, бүс нутгаар

Африк	Ази	Карибын болон Америкийн бүс	Европ	Номхон далай
Ботсвана	Бангладеш	Антигуа ба Барбуда	Кипр	Австрали
Камерун	Бруней	Багамын арлууд	Мальт	Фижи
Гамби	Даруссалам		Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс	Кирибати
Гана	Энэтхэг	Барбадос		Науру
Кени	Малайз	Белиз		Шинэ Зеланд
Свазилендийн вант улс	Мальдив	Канад		Папуа Шинэ Гвиней
	Пакистан	Доминикан		
Лесото	Сингапур	Гренада		Самоа
Малави	Шри Ланка	Гайана		Соломоны арлууд
Маврикий		Ямайк		Тонга
Мозамбик		Сент Люсиа		Тувалу
Намиби		Сент Киттс ба Невис		Вануату
Нигери		Сент-Винсент ба Гренадин		
Руанда		Тринидад ба Тобаго		
Сейшелийн арлууд				
Сьерра-Леон				
Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс				
Уганда				
Бүгд Найрамдах Нэгдсэн Танзани Улс				
Замби				

2009 оны 7 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Бүгд найрамдах Бангладеш Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 12(к)-д зааснаар Комисс нь хүний эрхийн салбарт ажиллаж буй төрийн бус байгууллага, институтийн хичээл зүтгэлийг дэмжих, тэдгээр байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, 12(о)-д зааснаар хүний эрхийн салбарт ажиллаж буй иргэний нийгмийн байгууллагуудад зөвлөх, туслах чиг үүрэгтэй.²⁹ Харин энэхүү чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгайлан зохицуулаагүй байна.

Хамтын нөхөрлөлийн улсуудын Хүний эрхийн санаачилгаас хийсэн “Хүний эрхийн төлөөх түншлэл: Иргэний нийгэм ба Хүний эрхийн үндэсний байгууллагууд” сэдэвт судалгааны өгүүлэлд иргэний нийгмийн байгууллагууд хүний эрхийн үндэсний байгууллагуудтай дараах хэлбэрээр идэвхтэй ажиллах шаардлагатай болохыг онцолжээ.³⁰ Үүнд:

- Хүний эрхийн үндэсний байгууллагуудыг Парисын зарчимд нийцүүлэн ил тод, хүртээмжтэй, оролцоотой байгуулах үйл явцыг дэмжих;
- Засгийн газрын бодлого боловсруулах үйл явцыг сайжруулахын тулд хүний эрхийн үндэсний байгууллагатай идэвхтэй харилцаж, албан болон албан бус арга хэрэгсэл ашиглах;
- Хүний эрхийн үндэсний байгууллагад хандахад нь хүний эрхийн зөрчлийн хохирогчдод тусалж, гомдол гаргах явцад нь хохирогчдыг дэмжиж ажиллах;
- Хүний эрхийн үндэсний байгууллагын зорилго, чиг үүрэг, хохирлыг барагдуулах механизмын талаарх ойлголт, мэдлэг түгээх сүлжээ бий болгох замаар Хүний эрхийн үндэсний байгууллагын олон нийтэд хүргэх ажлыг хөнгөвчлөх;
- Хүний эрх зөрчигдөж байгаа шорон, цагдан хорих байруудад иргэний хяналтын механизмын үүргийг гүйцэтгэхдээ хүний эрхийн үндэсний байгууллагатай хамтран ажиллах;
- “Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө” боловсруулахад засгийн газар, бусад оролцогчид лобби хийх, хүний эрхийн үндэсний байгууллагатай хамтран ажиллах;

²⁹ <http://nhrc.portal.gov.bd/sites/default/files/files/nhrc.portal.gov.bd/npfblock//NHRC%20Act%20English.pdf>

³⁰ Commonwealth Human Rights Initiative. Partnership for Human Rights: Civil Society and National Human Rights Institutions, *The International Journal of Not-for-Profit Law*, Volume 13, Issue 4, December 2011 <https://www.icnl.org/resources/research/ijnl/civil-society-and-national-human-rights-institutions>

- Хүний эрхийг дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын Олон улсын зохицуулах хороонд хүний эрхийн үндэсний байгууллагын ажлын гүйцэтгэлийн талаарх тайланг хүргүүлэх;
- Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн механизмд тайлагнах, боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэгт хүний эрхийн үндэсний байгууллагатай нягт хамтран ажиллах.



БҮЛЭГ 2

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаа дахь иргэний нийгмийн байгууллагын оролцоо



2.1.	Хууль тогтоомжид хийсэн дүн шинжилгээ	28
2.1.1.	Иргэний нийгмийн байгууллагын оролцооны талаарх үндэсний хууль тогтоомжийн тойм	28
2.1.2.	Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх иргэний нийгмийн байгууллагын оролцоотой зөвлөлийн талаарх харьцуулалт	30
2.1.3.	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай 2000 оны хуульд Орон тооны бус зөвлөлийн талаар тусгасан нь	34
2.1.4.	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай 2020 оны хуульд Иргэний нийгмийн зөвлөлийн талаар тусгасан нь	37
2.2.	Орон тооны бус зөвлөл, Иргэний нийгмийн зөвлөлийн үйл ажиллагаа	40
2.2.1.	Иргэний нийгмийн байгууллага ба хүний эрхийн үндэсний байгууллагын хамтын ажиллагааны тойм	40
2.2.2.	Орон тооны бус зөвлөл, Иргэний нийгмийн зөвлөлийн 2013-2020 оны үйл ажиллагааны тойм	41
2.2.3.	Орон тооны бус зөвлөл ба Иргэний нийгмийн зөвлөлийн дүрмийг шинжлэх нь	44
2.2.4.	Орон тооны бус зөвлөл, Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүнээр ажилласан хүний эрхийн шинжээчид	56

2.1. Хууль тогтоомжид хийсэн дүн шинжилгээ

2.1.1. Иргэний нийгмийн байгууллагын оролцооны талаарх үндэсний хууль тогтоомжийн тойм

Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолын хавсралт “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 1.1.5.9-д “Төрийн бус байгууллагаас засаг, төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих эрхийг нь хангах талаар тус тусын харьяа газруудаас хэрхэн ажиллаж байгааг Улсын Их Хурал, Засгийн газар нэгтгэн тогтмол дүгнэж байна” гэж, 2.1.2.14-т “Цагдан хорих, албадан саатуулах, баривчлах байр, хорих ангиудад аттестатчилал явуулж, хуулийн шаардлага хангахгүй, хүний эрх хохироож буй байруудын нөхцөлийг өөрчлөн сайжруулах арга хэмжээ авч, бүх хэлбэрийн хорих байр, газруудын үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлнэ” гэж заасан нь хүний эрхийг хангахад олон нийтийн хяналт тавих, тэрхүү хяналтыг төрийн бус байгууллага хэрэгжүүлэх үзэл баримтлалыг тогтоосон гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралт “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.7.1-т “төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах замаар авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих” гэж заасан нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагын оролцоо нэн чухал гэж үзсэнийг харуулж байна.

Улсын Их Хурлын дээрх хоёр тогтоолоос гадна үндэсний 30 гаруй хуульд төрийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих, төрийн бус байгууллагыг оролцуулах талаар тусгайлан заасан байна (Хавсралт 1-ийг үзнэ үү). Үүнээс харахад, иргэний нийгмийн байгууллагын оролцоо бүхий төрийн байгууллагын дэргэдэх зөвлөл, хороо зэрэг бүтцийг холбогдох хуульд дараах байдлаар тусгажээ. Үүнд:

1. Орчны бүсийн хөгжлийг зохицуулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд нутгийн иргэдийн оролцоог өргөжүүлэх зорилго бүхий орон тооны бус орчны бүсийн зөвлөл (1997);
2. Авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зөвлөмж өгөх зорилго бүхий Авлигатай тэмцэх газрын дэргэд ажиллах орон тооны бус Олон нийтийн зөвлөл (2006);
3. Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Хараат бус хэвлэл мэдээллийн орон тооны бус зөвлөл (2006);
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд ажиллах Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөл (2012);
5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүрэг бүхий Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Олон нийтийн хяналтын зөвлөл (2017);
6. Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллах орон тооны бус Үндэсний зөвлөлдөх хороо (2017);
7. Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд хэмжил зүйг хөгжүүлэх, хэмжил зүйн бодлого хэрэгжүүлэх, салбар хоорондын уялдааг хангах үүрэг бүхий орон тооны бус Хэмжил зүйн зөвлөл (2019);
8. Хүний эрхийн Үндэсний Комисс үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Иргэний нийгмийн зөвлөл (2020);
9. Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллах Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл (2020);
10. Музейн дүрэмд заасан бол музейн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Олон нийтийн зөвлөл (2021).

Эдгээр зөвлөл, хорооны хувьд төрийн байгууллага, олон нийтийн хооронд гүүр болох, тухайн салбарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нийтлэг шинжтэй байна.

2.1.2. Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх иргэний нийгмийн байгууллагын оролцоотой зөвлөлийн талаарх харьцуулалт

2000 оны 12 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 24.3-т “Комисс нь үйл ажиллагаагаа явуулахад туслах үүрэг бүхий өмгөөлөгчдийн холбоо, үйлдвэрчний эвлэлийн холбоо, хүний эрхийн асуудал эрхэлсэн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан орон тооны бус зөвлөл байгуулж болно” гэж заасан зохицуулалт 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгад уламжлагдаж, тус хуулийн 30.1-д “Комисс үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий иргэний нийгмийн зөвлөлтэй байна” гэж заасан.³¹

Тодруулбал, 2000 оны хуулиар дээр дурдсан зөвлөл нь Комисст “туслах” үүрэгтэй байсан бол 2020 оны хуулиар “дэмжлэг үзүүлэх” чиг үүрэгтэй болж өөрчлөгджээ. 2000 оны хуулийн 13.2-т Комиссын үйл ажиллагааг зургаан чиглэлээр заасан бөгөөд 2020 оны хуулийн 7.1-д Комиссын хэрэгжүүлэх 11 чиг үүргийг заасан. Дээр дурдсан зөвлөлийн хувьд Комиссын аль үйл ажиллагаа, чиг үүрэгт ямар хэлбэрээр туслах, дэмжих нь тусгагдаагүй тул Комиссоос батлах дүрмээр тодорхойлогдохоор байна.

Харин 2000 оны Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд Орон тооны бус зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг тусгаагүй байсан бол 2020 оны хуулийн 30.3-т тус шаардлагыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн гишүүн байх, эсхүл эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн багш, судлаач байх;
- хүний эрхийн чиглэлээр сүүлийн гурван жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан, эсхүл судалгаа, шинжилгээний ажил эрхэлсэн байх;
- улс төрийн намын харьяалалгүй байх, эсхүл түдгэлзсэн тухай шийдвэр гарсан байх.

Энэхүү судалгааны өмнөх хэсэгт авч үзсэн хүний эрхийн үндэсний байгууллага ба иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны талаарх үзэл

³¹ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2000, №48, <https://www.legalinfo.mn/law/details/360?lawid=360>
Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай (шинэчилсэн найруулга) хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2020, №08, <https://www.legalinfo.mn/law/details/15152?lawid=15152>

баримтлал, олон улсын жишиг, бусад улсын туршлагын талаарх мэдээлэл, дүн шинжилгээнд үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай 2000 болон 2020 оны хуулийн зохицуулалтыг харьцуулан судалж, холбогдох дүн шинжилгээ хийснийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиуд дахь Иргэний нийгмийн зөвлөлийн талаарх харьцуулалт

Харьцуулах нөхцөл	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн зохицуулалт	
	2000 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хууль	2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хууль
1. Оноосон нэр	Орон тооны бус зөвлөл	Иргэний нийгмийн зөвлөл
2. Чиг үүрэг	Комиссын үйл ажиллагаанд туслах	Комисс үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг үзүүлэх
3. Гишүүд	Өмгөөлөгчдийн холбоо, үйлдвэрчний эвлэлийн холбоо, хүний эрхийн асуудал эрхэлсэн төрийн бус байгууллагын төлөөлөл	Хүний эрхийн асуудал эрхэлсэн ашгийн төлөө бус хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн багш, судлаач
4. Гишүүнд тавигдах шаардлага	Байхгүй	<ul style="list-style-type: none"> ▪ хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн гишүүн байх, эсхүл эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн багш, судлаач байх; ▪ хүний эрхийн чиглэлээр сүүлийн гурван жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан, эсхүл судалгаа, шинжилгээний ажил эрхэлсэн байх; ▪ улс төрийн намын харьяалалгүй байх, эсхүл түдгэлзсэн тухай шийдвэр гарсан байх.

5. Үйл ажиллагааны төрөл, хэлбэр	Байхгүй	Байхгүй
6. Зөвлөлөөс гарах шийдвэр, түүний хэлбэр	Байхгүй	Байхгүй
7. Комиссоос зөвлөлийг дэмжих арга, хэлбэр	Байгүй	Байхгүй
8. Зөвлөлийн гишүүдийн ажил, үүргийн хуваарь	Байхгүй	Байхгүй
9. Зөвлөл, түүний гишүүдийн хүлээх хариуцлага	Байхгүй	Байхгүй
10. Зөвлөлийн гишүүдийн тоо	Байхгүй	Байхгүй
11. Зөвлөлийн гишүүдийн урамшуулал, санхүүжилт	Байхгүй	Байхгүй
12. Зөвлөлийн гишүүдийг сонгох, томилох зарчим, арга	Байхгүй	Байхгүй
13. Зөвлөл, түүний гишүүдийн бүрэн эрхийн хугацаа	Байхгүй	Байхгүй
14. Зөвлөлийн шийдвэрийг заавал биелүүлэх эсэх	Байхгүй	Байхгүй
15. Зөвлөлийн үйл ажиллагаанд хориглох зүйл	Байхгүй	Байхгүй
16. Зөвлөлөөс бусад байгууллага, албан тушаалтантай харилцах асуудал	Байхгүй	Байхгүй

Дээрх харьцуулалтад үндэслэн хийсэн дүн шинжилгээг доор харуулав. Үүнд:

1. Зөвлөлд иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг заавал хангах нөхцөлийг тодорхой болгосон.
2. Зөвлөлийн чиг үүрэг Комиссын үйл ажиллагаатай шууд уялдаатай байх бөгөөд Зөвлөлийн ач холбогдол, чадавхын талаарх үнэлэмж дээшилсэн.
3. Зөвлөл нь иргэний нийгмийн олон талт төлөөллийг хангах механизм байх уламжлал хадгалагдсан. Зөвлөлийн гишүүнд их, дээд сургуулийн багш, судлаачийг нэмэлтээр оруулсан нь тус зөвлөлийн шийдвэр, үйл ажиллагаа баримт, судалгаанд суурилсан байхыг чухалчилсан гэж үзэж болох юм.
4. Зөвлөлийн гишүүн нь хараат бус байх, хүний эрхийн асуудлаар мэргэшсэн, туршлагатай байх шаардлагыг тогтоосон гэж үзэж болохоор байна. Зөвлөлийн гишүүнийг Комисс өөрөө шалгаруулж, томилох боломжтой.
5. Зөвлөлийн гүйцэтгэх үйл ажиллагаа, гаргах шийдвэрийн төрөл хэлбэр, Зөвлөл болон түүний гишүүдэд Комисс хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар тусгах шаардлагатай.
6. Мөн Зөвлөлийн гишүүн тус бүрийн болон хамтран гүйцэтгэх үүрэг, хэрэгжүүлэх ажлын хуваарийг тогтоох, Зөвлөл, түүний гишүүд үйл ажиллагаа явуулахгүй, тайлангаа тавихгүй байгаа нөхцөлд хүлээлгэх хариуцлагын механизмыг тусгах нь зүйтэй.
7. Зөвлөлийн гишүүдийн тооны дээд, доод хязгаарыг тогтоох, Зөвлөлийн гишүүд үйл ажиллагаа хэрэгжүүлсний төлөө цалин хөлс авахгүй, Комиссоос санхүүгийн хувьд давуу байдал олж авахгүй байх талаар тусгах шаардлагатай.
8. Зөвлөлийн гишүүдийг сонгох, томилох, чөлөөлөх зарчим, аргыг тусгахын зэрэгцээ бүрэн эрхийн хугацааг Комиссын гишүүдийн бүрэн эрхийн хугацаатай уялдуулан тогтоож болох юм.
9. Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг Комисс хэрхэн хүлээн авах, заавал биелүүлэх эсэхийг тогтоох шаардлагатай.
10. Зөвлөлийн гишүүн байх нь Комиссын болон бусад байгууллагын нэр хүнд, үйл ажиллагаанд халдах нөхцөл болохгүй байх зэрэг үйл ажиллагааны хязгаарлалт, хориглох зүйлийг тусгах нь зүйтэй.
11. Мөн Зөвлөлийн хувьд зөвхөн Комисстой харилцах эсэх, төрийн болон иргэний нийгмийн бусад байгууллагатай бие даан харилцах эсэхийг тусгах шаардлагатай.

Дээрх дүн шинжилгээнд дурдсан асуудлыг хэрхэн, ямар агуулгаар тусгахыг шийдэхийн тулд олон улсын жишиг, бусад орны туршлагыг харгалзах төдийгүй хуулийн зохицуулалттай холбоотой хууль тогтоогчийн үзэл баримтлалыг харгалзан үзэх хэрэгтэй. Энэ асуудлын хүрээнд хуулийн төслийг хэлэлцэх, батлах үеийн холбогдох тэмдэглэлтэй танилцлаа.

2.1.3. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай 2000 оны хуульд Орон тооны бус зөвлөлийн талаар тусгасан нь

Монгол Улсын Засгийн газраас 2000 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд хүргүүлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн төслийн танилцуулгад “Хүний эрхийн асуудлаар ажилладаг (шүүх, прокурор, өмгөөлөх гэх мэт) төрийн болон төрийн бус байгууллагууд үйл ажиллагаагаа зохицуулах, уялдуулах, тэдгээр байгууллагын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, НҮБ-ын төрөлжсөн байгууллага болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах зэргээр хүний эрхийн асуудлыг нэг байгууллага төвлөрүүлэн эрхлэх боломж бүрдэнэ” гэжээ.³² Энэхүү танилцуулгыг дагалдуулсан хуулийн төслийн 23.3-т “Комиссын үйл ажиллагаагаа явуулахад туслах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл, ажлын хэсэг байгуулж болно” гэж тусгасан байна. Мөн тус хуулийн төсөлд Гадаад хэргийн яамнаас “Комиссын гишүүнд нэр дэвшүүлэхэд иргэний нийгмийн төлөөлөл (хүний эрхийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, хуульчид, эмч, сэтгүүлчдийн байгууллага, нэрт эрдэмтдийн төлөөлөгчид)-ийг хангавал зохино гэсэн утгатай заалт оруулах” гэж санал өгчээ.³³

Хуулийн төслийн “23.3. Комиссын үйл ажиллагаагаа явуулахад туслах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл, ажлын хэсэг байгуулж болно” гэх хэсэгт УИХ-ын гишүүн Ц.Оюунбаатар “үүрэг бүхий гэсний дараа Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, хүний эрхийн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан” гэж нэмэх санал гаргажээ. Эндээс харахад, УИХ-ын гишүүн Ц.Оюунбаатар санал гаргаж, Хууль зүйн байнгын хороогоор дэмжигдсэнээр Комиссын үйл ажиллагаагаа явуулахад туслах үүрэг

³² Монгол Улсын Засгийн газраас 2000 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр УИХ-д хүргүүлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн төслийн талаарх танилцуулга.

³³ Монгол Улсын Засгийн газраас 2000 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр УИХ-д хүргүүлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн төслийн талаарх танилцуулгын хавсралт, Яамдаас ирсэн саналын товчоон.

бүхий орон тооны бус зөвлөл, ажлын хэсэг нь иргэний нийгмийн байгууллагыг төлөөлөх орон тооны бус зөвлөл болж өөрчлөгджээ.

Энэ нь 2000 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт”-д “...тус Байнгын хороо 2000 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд ... хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, өргөн мэдүүлсэн төсөлд дараах нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж байна. Үүнд: ... 10/ Төслийн 23.3-ын ‘үүрэг бүхий’ гэсний дараа ‘өмгөөлөгчдийн холбоо, үйлдвэрчний эвлэлийн холбоо, хүний эрхийн асуудал эрхэлсэн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан’ гэж нэмэх” гэж тусгагдсан байгаагаар нотлогдож байна.³⁴ Улсын Их Хурлын чуулганы 2000 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж, тус байнгын хороо 2000 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлуудыг төсөлд бүрэн тусгажээ. Ингэснээр тус санал “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Хууль зүйн байнгын хорооны танилцуулга”, дагалдах төсөлд баталгаажсан байна.³⁵

Дээрх зохицуулалттай холбоотойгоор Улсын Их Хурлын 2000 оны намрын чуулганы 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны протоколд “Л.Энэбиш: Төслийн 23.3-ын “үүрэг бүхий” гэсний дараа “Өмгөөлөгчдийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Хүний эрхийн асуудал эрхэлсэн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан” гэж нэмье гэсэн санал байна. Оюунбаатар гишүүний санал байна. Хууль зүйн байнгын хороогоор дэмжигдсэн санал байна. Энэ саналыг хүлээж авъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 50 гишүүн орсноос зөвшөөрсөн 42, татгалзсан 8, 84 хувийн саналаар энэ саналыг хүлээж авч байна” гэжээ.³⁶

Улсын Их Хурлын 2000 оны намрын чуулганы 11 дүгээр сарын 28-ны өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүд дараах байдлаар хэлэлцжээ.³⁷

³⁴ 2000 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт”.

³⁵ 2000 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Хууль зүйн байнгын хорооны танилцуулга”.

³⁶ Улсын Их Хурлын 2000 оны намрын чуулганы 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны протокол, Дугаар 14, 51-52 дахь тал.

³⁷ Улсын Их Хурлын 2000 оны намрын чуулганы 11 дүгээр сарын 28-ны өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдааны протокол, Дугаар 14, 13-14 дэх тал.

“ УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга Ц.Шаравдорж: 25.3-аас “ажлын хэсэг” гэснийг хасаж 19.3 болгож, “Комиссын гишүүн нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа талаарх асуудлаар шалгалт хийх, хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулахад туслах зорилгоор ажлын хэсэг байгуулж болно” гэж Оюунбаатар гишүүн санал оруулсан байна. Тайлбар хийх үү?

“ Ц.Оюунбаатар: Гол санаа нь 23.3-т их чухал заалт орж байгаа юм. Хүний эрхийн талаарх төрийн бус байгууллагуудын оролцоог Хүний эрхийн Үндэсний Комисстой харилцах харилцаа, хамтын ажиллагаа, оролцоог тодорхойлсон заалт дээр ажлын хэсэг гэсэн ач холбогдол багатай зүйл орчхоод байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл, энэ 23.3 дахь заалтын ач холбогдлыг бууруулах тийм юм орчхоод байгаа юм. Ийм учраас “Ажлын хэсгийг тусад нь гаргах шаардлагатай” гэсэн миний санал байгаа юм. Өөрөөр хэлбэл, Өмгөөлөгчдийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн байгууллага, хүний эрхийн асуудал эрхэлсэн төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулсан орон тооны бус зөвлөл байна гээд зарчмын чухал заалт орж байгаа байхгүй юу. Энэ зөвлөлийн ажиллах журам, Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтын ажиллагаа явуулах журам энэ тэр бүгд гарна. Магадгүй ажлын хэсэг энэ журам дотроо ч юм уу орж болох зүйл л дээ. Зайлшгүй хуульчлах шаардлага байна уу, үгүй юү? Зүгээр энэ зүйлд байж болохгүй. Тусад нь бие даалгаж гаргая. Ер нь цаашдаа байх шаардлага ч байгаа юм уу, үгүй юү?

“ Ц.Шаравдорж: Эрхэм гишүүн маань ажлын хэсэг дээр жаахан ач холбогдол өгч, тусад нь гаргая гэсэн томъёолол оруулж байгаа юм байна шүү дээ. Ер нь энд ийм заалт байгаа шүү. “25.3. Комисс нь үйл ажиллагаагаа явуулахад туслах үүрэг бүхий Өмгөөлөгчдийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбоо, хүний эрхийн асуудал эрхэлсэн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан орон тооны бус зөвлөл, ажлын хэсэг байгуулж болно” гэсэн ийм томъёолол байгаа шүү дээ, орчхоод байгаа юм. Эрхэм гишүүн маань ажлын хэсэг гэдгийг ач холбогдол өгч тусад нь гаргая гэж байгаа юм. Ямар ч гэсэн санал гаргасан учраас саналыг хураалгая.

“ ... Ц.Оюунбаатар: ...Хамгийн гол нь би ажлын хэсэг дээр ач холбогдол өгсөндөө биш. Тэр орон тооны бус зөвлөл байна гэсний ард ажлын хэсэг гэдэг үйл ажиллагааны жирийн процедур оруулсан байхгүй юу. Тэгэхээр

энийг хасаач ээ гэсэн, хасаж болохгүй гэхээр зэрэг тусад нь оруулаад байгаа юм. Тэр орон тооны бус зөвлөл гэдэг онцгой үүрэгтэй, нөгөө төрийн бус байгууллагуудын хүний эрхийн салбарт ажиллах ажиллагааг ийш нь оруулсан байхгүй юу. Тэгэхээр ажлын хэсэг гэдгийг тусад нь зүйл болгохгүй хасаж болно. Энүүгээр санал хураалгахыг би дэмжиж байна. Тэрнээс биш ажлын хэсэг энд байж болохгүй. Энэ заалтад байж болохгүй. Орон тооны бус зөвлөл байна гээд, энэ зөвлөл ажлын хэсэг биш байнгын ажиллагаатай, тэр хүний эрхийн Комисстой байнга хамтарч ажиллаж байх, тэр илтгэл судалгаан дээр хамт сууж байх ийм хүмүүс байгаа. Манай Болормаа, Одончимэд гишүүдийн хэлээд байгаа тэр олон оролцоог энэ орон тооны бус зөвлөл хангах юм. Гэтэл ажлын хэсэг гээд түр зуур нэг удаагийн шалгалтад орох энэ юуг энд оруулах шаардлагагүй юм. Хэрэв байвал тусад нь зүйл анги байгуулаад бий болгоё гэсэн чинь их хүчтэй ороод ирсэн байна л даа.



Ц.Шаравдорж: 25.3-аас ажлын хэсэг гэдгийг хасах саналаар санал хураалгая. Эрхэм гишүүд ээ анхаараарай. Зургаан гишүүн байна. Цөөн байна уу? Алга байна. За ингээд шийдлээ.

Эндээс харахад, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай 2000 оны хууль дахь Орон тооны бус зөвлөлийн зохицуулалт нь төрийн бус байгууллагуудыг хүний эрхийн салбарт ажиллах механизм бүрдүүлэх, иргэний нийгмийн байгууллагуудыг Хүний эрхийн Үндэсний Комисстой байнга хамтарч ажиллах, энэ хүрээнд Комиссоос Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэл бичихэд тус зөвлөл хамт ажиллахаар тусгаж байжээ.

2.1.4. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай 2020 оны хуульд Иргэний нийгмийн зөвлөлийн талаар тусгасан нь

2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, танилцуулгад иргэний нийгмийн зөвлөлийн талаар тухайлан дурдаагүй байна.³⁸ Харин “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зардлын тооцооны тайлан”-д хуулийн 30.4-т

³⁸ Хууль зүйн байнгын хороо, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл, <http://forum.parliament.mn/projects/10695>

“Иргэний нийгмийн зөвлөлийн дүрмийг Комиссын хуралдаанаар баталж мөрдүүлнэ” гэж заасантай холбоотой журам боловсруулж, батлуулахад таван өдөр буюу 40 цаг зарцуулна гэж тооцжээ.³⁹ Тодруулбал, иргэний нийгмийн зөвлөлд өөр зардал гарахгүй гэж үзжээ.

Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 10 дугаар сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хорооны 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн.⁴⁰ Тус өдрийн хуралдааны тэмдэглэлийн 8-17 дахь талд дээрх хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхтэй холбоотой хэлэлцүүлгийг тусгасан байна.⁴¹ Энэ өдрийн хэлэлцүүлэгт тус хуулийн 30 дугаар зүйл буюу иргэний нийгмийн зөвлөлийн талаар хэлэлцээгүй.

Улсын Их Хурал 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн. Тус хуралдааны тэмдэглэлийн 54-82 дахь талд хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхтэй холбоотой хэсгийг тусгажээ. Энэ өдрийн хэлэлцүүлэгт мөн л тус хуулийн 30 дугаар зүйл буюу иргэний нийгмийн зөвлөлийн талаар хэлэлцээгүй байна.⁴²

Ажлын хэсэг дээрх асуудлыг 2019 оны 12 дугаар сарын 23, 24-ний өдрүүд, 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга”-ыг Хууль зүйн байнгын хороонд хүргүүлжээ. Тус танилцуулгад

³⁹ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зардлын тооцооны тайлан, 2018.

⁴⁰ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, 2019 оны 10 дугаар сарын 22.

⁴¹ Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы Хууль зүйн байнгын хорооны 10 дугаар сарын 22-ны өдөр (Мягмар гараг)-ийн хуралдааны тэмдэглэл, <http://parliament.mn/files/85628>

⁴² 2019 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл (Пүрэв гараг, 2019 оны 10 дугаар сарын 24), <http://parliament.mn/n/35ky>

иргэний нийгмийн зөвлөлтэй холбоотой асуудлыг мөн тусгаагүй.⁴³

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийн 32-44 дэх талд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн үргэлжлэлийг тусгажээ. Энэ өдрийн хэлэлцүүлэгт тус хуулийн 30 дугаар зүйл буюу иргэний нийгмийн зөвлөлийн талаар хэлэлцээгүй байна.⁴⁴

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэлийн 78-92 дахь талд тус хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг тусгасан.⁴⁵ Энэ өдрийн хэлэлцүүлгээр тус хуулийн 30 дугаар зүйлд заасан зохицуулалтын талаар мөн хэлэлцээгүй.

Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийн 9-15 дахь талд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг тусгасан ч хуулийн төслийн 30 дугаар зүйлд заасан зохицуулалтын талаар хэлэлцээгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэлийн 57-65 дахь талд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийн талаар тусгажээ.⁴⁶ Энэ өдрийн хэлэлцүүлэгт ч мөн хуулийн 30 дугаар зүйлд заасан зохицуулалтын талаар хэлэлцээгүй байна.

Эндээс үзэхэд, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 30 дугаар зүйлд оруулсан Иргэний нийгмийн зөвлөлийн талаарх зохицуулалт нь хууль тогтоогчдод нэгэнт илэрхий буюу иргэний нийгмийн байгууллагын оролцоог хууль тогтоогчид нэгэнт хүлээн зөвшөөрсөн гэж үзэж болох юм.

⁴³ "Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга", 2020 оны 1 дүгээр сарын 8, <http://forum.parliament.mn/projects/10695>

⁴⁴ Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл (Лхагва гараг, 2020 оны 1 дүгээр сарын 15), <http://parliament.mn/files/89454>

⁴⁵ УИХ-ын 2019 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл (Пүрэв гараг, 2020 оны 1 дүгээр сарын 16), <http://parliament.mn/files/89730>

⁴⁶ УИХ-ын 2019 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл (Пүрэв гараг, 2020 оны 1 дүгээр сарын 23), <http://parliament.mn/n/ixmy>

2.2. Орон тооны бус зөвлөл, Иргэний нийгмийн зөвлөлийн үйл ажиллагаа

2.2.1. Иргэний нийгмийн байгууллага ба хүний эрхийн үндэсний байгууллагын хамтын ажиллагааны тойм

Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд Орон тооны бус зөвлөлийг 2002 оноос хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоотойгоор байгуулан ажиллуулж байна.⁴⁷ Хүний эрх, хөгжлийн төлөөх Азийн Форумын Удирдах зөвлөлийн дарга, Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож “Иргэний нийгмийн байгууллага ба хүний эрхийн үндэсний байгууллагын хамтын ажиллагааны үр нөлөө, түүнийг сайжруулах нь: Олон улсын туршлага” сэдэвт 2015 оны илтгэлдээ иргэний нийгмийн байгууллага болон хүний эрхийн үндэсний байгууллагын хамтын ажиллагааны үр нөлөөг сайжруулах талаар “Хүний эрхийн Үндэсний Комисс нь хүний эрхийн үндэсний механизмын гол цөм болох учиртай тул бие даасан хараат бус байдлаа хангах хууль тогтоомжийг яаралтай батлуулах. Ингэхдээ иргэний нийгмийн байгууллагатай өргөн хүрээний хэлэлцүүлэг зохион байгуулах; АННИ сүлжээний хүрээнд бичигдсэн илтгэлээр өгөгдсөн зарим зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан ч зарим зөвлөмж удаа дараа өгөгдөж байгааг анхаарах. Үүнийг хэрэгжүүлэх талаар хэлэлцэж, арга замыг тодорхойлох; Олон улсын гэрээ, конвенцуудын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллага, хүний эрхийн төрийн бус байгууллагуудын саналыг авах, оролцоог нэмэгдүүлэх; Жил бүр бэлтгэдэг “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл”-ийг бэлтгэхэд төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, саналыг нь авах” хэмээн дурджээ.⁴⁸

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2015-2020 оны стратеги төлөвлөгөөнд хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, чадавхжуулах, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хүний эрхийн үнэлгээ, шинжилгээ, нөлөөллийн үйл ажиллагаа хийхээр тусгасан байна.⁴⁹ Тодруулбал, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2015 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн

⁴⁷ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны тайлан, 2018.

⁴⁸ Г.Уранцоож, “Иргэний нийгмийн байгууллага ба хүний эрхийн үндэсний байгууллагын хамтын ажиллагааны үр нөлөө, түүнийг сайжруулах нь: олон улсын туршлага”, “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл, 2016/01 (47) дугаар, 40 дэх тал.

⁴⁹ Ж.Бямбадорж, “Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил”, “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл, 2016/01 дугаар, 8 дахь тал.

тогтоолоор баталсан “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын стратеги төлөвлөгөө (2015-2020 он)”-ний 4.4 дэх зорилтод “Хүний эрх, эрх чөлөөний талаарх тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх бодлого, шийдвэрийг гарган хэрэгжүүлэхэд төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, хамтран ажиллах” гэж, 4.6 дахь зорилтод “Даяарчлалын үйл явцад идэвхтэй байр суурь баримталж, НҮБ болон бүс нутгийн, гадаад, дотоодын байгууллагатай олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх” хэмээн тус тус тусгасан бөгөөд “Хүний эрхийг хүндэтгэх, сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих үйл ажиллагаанд бүх талын оролцоо, санаачилга, дэмжлэг нэмэгдсэнээр хүний эрхийг хамгаалагчдын эрхийн хэрэгжилт сайжирсан байна” гэж хүлээгдэж буй үр дүнг тодорхойлжээ.⁵⁰

2.2.2. Орон тооны бус зөвлөл, Иргэний нийгмийн зөвлөлийн 2013-2020 оны үйл ажиллагааны тойм

“Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын стратеги төлөвлөгөө (2015-2020 он)”-ний дагуу сүүлийн найман жилийн буюу 2013-2020 оны Орон тооны бус зөвлөл, Иргэний нийгмийн зөвлөлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг энд авч үзэв.

- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2013 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланд дурдсанаар, Орон тооны бус зөвлөлийн хурлыг 2013 оны 3 дугаар сарын 13, 6 дугаар сарын 17-ны өдрүүдэд зохион байгуулжээ. 2013 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн хурлаар Комиссын шинээр томилогдсон гишүүн Н.Ганбаярыг танилцуулах, Комиссын 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон 2013 оны I улиралд хийсэн ажлын тайланг хэлэлцсэн байна. Тус хуралд Комиссын дарга, гишүүд болон Орон тооны бус зөвлөлийн 16 гишүүн нийт 19 хүн оролцжээ. 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар Комиссын эхний хагас жилд хийсэн үйл ажиллагааны тайлан болон Орон тооны бус зөвлөлийн гишүүн байгууллагуудаас явуулж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонсжээ. Хуралд Орон тооны бус зөвлөлийн 21 гишүүнээс 7 гишүүн оролцсон байна.⁵¹

⁵⁰ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын стратеги төлөвлөгөө (2015-2020 он), <https://bit.ly/3ewgmNI>

⁵¹ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2013 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, 2013.07.10, 18-19 дэх тал.

- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2014 оны үйл ажиллагааны тайланд дурдсанаар, Комиссын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг Комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөлийн гишүүдэд танилцуулан санал авч, Ерөнхийлөгчийн Тамгын газарт хуулийн төслийн үзэл баримтал, шинэчилсэн найруулгын төслийн хамт хүргүүлжээ. Орон тооны бус зөвлөлийн өргөтгөсөн хурал 2014 онд гурван удаа зохион байгуулагджээ. Хүний эрхийн Үндэсний Комиссын Орон тооны бус зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж 2014 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн байна. Хурлын шийдвэрийн биелэлтийг ханган Орон тооны бус зөвлөлийн гишүүдтэй байнга харилцан, эргэх холбоотой ажиллажээ. Мөн Орон тооны бус зөвлөлийн гишүүдийн танилцуулгыг хэвлэн гаргаж, Зөвлөлийн 2014 оны төлөвлөгөөг баталсан байна.⁵²
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2015 оны үйл ажиллагааны тайланд дурдсанаар, Орон тооны бус зөвлөлийн ээлжит хурал улирал тутамд зохион байгуулагдаж, үйл ажиллагааны төлөвлөгөө, 2015-2020 оны стратеги төлөвлөгөөг танилцуулан гишүүдийн санал, зөвлөмжийг Комиссын стратеги төлөвлөгөөнд тусгасан байна. Хүний эрхийн тулгамдаж байгаа болон цаг үеийн зарим асуудлаар гишүүд санал солилцсоны зэрэгцээ Комиссын төсөв санхүүжилттэй холбоотой мэдээлэл бэлтгэн гишүүдэд танилцуулжээ.⁵³
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2016 оны үйл ажиллагааны тайланд дурдсанаар, Орон тооны бус зөвлөлийн хурал 11 дүгээр сарын 21-нд зохион байгуулагджээ. Хурлаар Комиссын сүүлийн үед хийгдсэн томоохон үйл ажиллагааг гишүүдэд танилцуулж, 2017 онд Зөвлөлийн хүрээнд хэрэгжүүлэх ажил, мөн олон улсын хүний эрхийн өдрийг угтаж хамтран хийх ажлын тухай хэлэлцсэн байна.⁵⁴
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2017 оны үйл ажиллагааны тайланд дурдсанаар, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 16 дахь илтгэлийг Орон тооны бус зөвлөлийн гишүүдэд хүргүүлжээ. Бизнесийн салбарт хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, стратеги боловсруулах талаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулах зорилтын хүрээнд Орон тооны

⁵² Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2014 оны үйл ажиллагааны тайлан, 5, 19 дэх тал.

⁵³ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2015 оны үйл ажиллагааны тайлан, 30 дахь тал.

⁵⁴ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2016 оны үйл ажиллагааны тайлан, 39 дэх тал.

бус зөвлөлийн гишүүдтэй санал солилцсон байна. Комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөлийн ээлжит хурал 2017 оны 5 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулагдаж, Комиссын 2017 оны I дүгээр улирлын ажлын тайлан, II, III улиралд иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Комиссын Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл танилцуулжээ. Мөн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлийн талаар Захиргаа хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ө.Ундрах танилцуулж, хүний эрхийн тулгамдаж байгаа болон цаг үеийн зарим асуудлаар гишүүд санал солилцсон байна. Хурлаас Хүний эрхийн Үндэсний Комиссын энэ удаагийн илтгэлд тусгагдсан асуудлуудыг Орон тооны бус зөвлөлийн гишүүд дэмжиж, тус тусын хариуцсан чиглэлийн хүрээнд төр засаг, олон нийтэд таниулан сурталчлах ажил зохион байгуулахаар ярилцсан байна. Орон тооны бус зөвлөлийн 2017 оны хоёр дахь хурал 12 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулагдаж, хуучин гишүүддээ талархал илэрхийлэн, үйл ажиллагааны тайланг нэгтгэн танилцуулжээ. Мөн шинээр томилогдсон гишүүдийн анхны уулзалт болсон бөгөөд уулзалтын үеэр Зөвлөлийн гишүүдээс 2018 онд Комисстой хамтран ажиллах ажлын санал авч Зөвлөлийн дүрэм, түүний ажиллах үүрэг, чиглэлийг танилцуулсан байна.⁵⁵ Тус хурлаар Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж, Зөвлөлийн даргаар Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн П.Оюунчимэг ажиллаж байжээ.⁵⁶

- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2018 оны үйл ажиллагааны тайланд дурдсанаар, Орон тооны бус зөвлөлийн гишүүдийн уулзалтыг жилд дөрвөн удаа зохион байгуулж, гишүүдийг Комиссын үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний санаачлан зохион байгуулж буй ажлуудыг бусад байгууллагынхтай холбон уялдуулах зэргээр ажиллажээ. 2018 оны Орон тооны бус зөвлөлийн ээлжит хурлуудаар тодорхой асуудлуудыг хэлэлцсэн байна. Тухайлбал, 3 дугаар сарын 2-ны өдрийн хурлаар Комиссын 2018 оны төлөвлөгөө, Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл бичих чиглэлийг тус тус танилцуулж, 2018 онд Комисстой хамтран ажиллах чиглэлээр гишүүдээс санал авч Комиссын төлөвлөгөөнд тусгуулжээ. 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хурлаар Комиссын хагас жилийн тайлан болон III улиралд Комиссоос хэрэгжүүлэх ажил, Хүний эрхийн хамгаалагчийн

⁵⁵ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2017 оны үйл ажиллагааны тайлан, 53, 59 дэх тал.

⁵⁶ ХЭҮК-ын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн бүрэлдэхүүн, 2020.02.17, <https://bit.ly/3tJ3WHK>

эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг танилцуулж, нөлөөллийн үйл ажиллагаанд гишүүдийг татан оролцуулах чиглэлээр мэдээлэл хийжээ. 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар Зөвлөлийн гишүүд хүүхдийн хорих ангийн үйл ажиллагаатай танилцаж, хууль зөрчсөн хүүхдийг нийгэмшүүлэх үйлчилгээнд Орон тооны бус зөвлөлийн гишүүдээс хийсэн үнэлгээг танилцуулж, 2019 онд Комисстой хамтран ажиллах санал авчээ. Зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд гарсан нэг чухал амжилт нь гишүүд дотроо багт хуваагдан ажиллаж хүний эрхийн тодорхой асуудлын хүрээнд хамтран ажиллах арга барил нэвтрүүлж, тодорхой үр дүнд хүрсэн байна. Мөн хүүхдийн сургалт, хүмүүжлийн “Нарт хангай” төвийн ажиллагаатай танилцаж, 2019 онд Гэр бүл, хүүхэд, залуучуудын газартай хамтран тус төвийн хүүхэд хамгааллын асуудлыг сайжруулах чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулан ажиллахаар болжээ.⁵⁷

- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2019 оны үйл ажиллагааны тайланд дурдсанаар, Орон тооны бус зөвлөлийн гишүүдийн санаачилгаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын “Нарт хангай” төвийн хүүхэд хамгааллын асуудлыг сайжруулах чиглэлээр тус төвийн үйл ажиллагаатай танилцаж, ажлыг нь хэрхэн сайжруулах чиглэлээр Комиссын гишүүний зөвлөмжийг хүргүүлсэн байна. Мөн Орон тооны бус зөвлөлийн хурлыг 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдөр хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад зохион байгуулж, зөвлөлийн гишүүдийн санаачилгаар хэрэгжүүлсэн сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын үйл ажиллагаа болон хүмүүжиж буй хүүхдийн нөхцөл байдалтай танилцсаны дагуу хийсэн “хууль зөрчсөн хүүхдийг нийгэмшүүлэх үйлчилгээнд хийсэн үнэлгээ”-ний дүнг Зөвлөлийн гишүүд тус байгууллагын дарга, алба хаагч нарт танилцуулжээ. Мөн хурлаар Комиссын 2019 оны төлөвлөгөө, хэрэгжүүлэх үйл ажиллагааг гишүүдэд танилцуулж, хамтран ажиллах асуудлаар гишүүдээс санал авсан байна. Мөн энэ үеэр Орон тооны бус зөвлөлийн гишүүд болон Комиссын зүгээс хүмүүжигч хүүхдүүдэд зориулсан ном, хичээлийн хэрэгсэл, сагсан болон одон бөмбөгийн хэрэглэл зэрэг хүүхэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх спортын хэрэглэгдэхүүнийг бэлэглэжээ. Орон тооны бус зөвлөлийн хоёр дахь хурал 11 дүгээр сарын 28-ны өдөр болж, Комиссын 2019 оны үйл ажиллагааг дүгнэн, 2020 онд зохиох ажилдаа Орон тооны бус зөвлөлийн саналыг авчээ.⁵⁸

⁵⁷ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2018 оны үйл ажиллагааны тайлан, 47, 48 дахь тал.

⁵⁸ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2019 оны үйл ажиллагааны тайлан, 39 дэх тал.

- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2020 оны үйл ажиллагааны тайланд дурдсанаар, Иргэний нийгмийн зөвлөлийн дөрвөн удаагийн хурлын бэлтгэл ажлыг хангаж, хугацаанд нь зохион байгуулахад 2,000,000 төгрөг төсөвлөсөн хэдий ч Ковид-19 цар тахлын улмаас зарласан өндөржүүлсэн бэлэн байдал, олныг хамруулсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу тодорхойгүй хугацаагаар хойшилсоор Комиссын шинэ гишүүд томилогдсоны дараа буюу 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан байна.⁵⁹ Иргэний нийгмийн зөвлөлийн бүрэлдэхүүн нь 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар хүний эрхийн төрөл тус бүрийг төлөөлөх нийт 19 гишүүнтэй болсон байна.

Дээрх байдлаас дүгнэхэд, Зөвлөлийн үйл ажиллагааны хүрээ, хурлын давтамж зэрэг асуудлыг Комиссын тогтоосноор тодорхойлж байна. Зөвлөлийн хувьд улиралд нэг удаа, жилд нийт дөрвөн удаа ээлжит хурал хийх хуваарьтай явж иржээ. Энэ нь Зөвлөлийн ажлын үр дүнг дүгнэж хэлэлцэх, дараагийн зорилт дэвшүүлэхэд тохиромжтой хугацаа байж болох юм. Гэвч яаралтай хариу арга хэмжээ авахад энэ нөхцөл тохиромжтой эсэх нь эргэлзээтэй. Хэдий тийм ч судалгаанд хамруулсан найман жилийн хугацаанд Зөвлөл ээлжит бусаар буюу төлөвлөснөөс өөрөөр хуралдсан тухай мэдээлэл байсангүй. Судалгаанд хамруулсан найман жилийн хугацаан дахь Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөл, Иргэний нийгмийн зөвлөлийн үйл ажиллагааг үнэлж үзэхэд Хүний эрхийн Үндэсний Комисстой болон өөр хоорондоо, мөн бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр дараах боломж байна гэж дүгнэж болохоор байна. Үүнд:

- Хүний эрхийн зөрчлийг зогсоох, сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд Зөвлөлөөс Комиссын гишүүнийг татан оролцуулах;
- Зөвлөлөөс Комиссын үйл ажиллагаатай бүрэн танилцах, үнэлэх;
- Комисс болон Зөвлөлөөс мэдээлэл солилцох, үйл ажиллагааг уялдуулах, хамтран ажиллах чиглэлээр санал гаргах;
- Зөвлөлийн хувьд Комиссын үйл ажиллагааг төлөвлөхөд болон тухайн үйл ажиллагааны нэг хэсэг болж оролцох;
- Зөвлөлийн гишүүд Комисст хандахаас гадна хоорондоо хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах;

⁵⁹ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2020 оны үйл ажиллагааны тайлан, 2021.01.05, 31, 32 дахь тал.

- Комиссоос Зөвлөлийг бусад байгууллагатай холбох, үйл ажиллагааг нь уялдуулах буюу “гүүр” болж ажиллах;
- Зөвлөлийн гишүүдийн хамтын ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх.

2.2.3. Орон тооны бус зөвлөл ба Иргэний нийгмийн зөвлөлийн дүрмийг шинжлэх нь

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2013 оны 34 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Орон тооны бус зөвлөлийн дүрэм”, 2014 оны 3 дугаар сарын 24-ний тушаалын хавсралтаар “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Орон тооны бус зөвлөлийн дүрэм”, 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн А/06 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн дүрэм”-ийг тус тус баталжээ. Эдгээр дүрмээр зохицуулсан харилцааг дараах хүснэгтэд харьцуулан харуулав.

Хүснэгт 3. Орон тооны бус зөвлөл (ОТБЗ) ба Иргэний нийгмийн зөвлөлийн дүрмийн харьцуулалт

Үзүүлэлт	2013 оны дүрэм	2014 оны дүрэм	2020 оны дүрэм
Зөвлөлийн бүрэлдэхүүн	Дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан иргэний нийгмийн байгууллагыг төлөөлсөн нийт 21 хүний бүрэлдэхүүнтэй байна. ОТБЗ-ийн дарга нь ХЭҮК-ын гишүүн, нарийн бичгийн дарга нь ХЭҮК-ын Ажлын албаны ажилтан байх бөгөөд тэдгээрийг Комиссын дарга томилно.	Дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан иргэний нийгмийн байгууллагыг төлөөлсөн нийт 21 хүний бүрэлдэхүүнтэй байна. ОТБЗ-ийн дарга нь ХЭҮК-ын гишүүн, нарийн бичгийн дарга нь ХЭҮК-ын Ажлын албаны ажилтан байх бөгөөд тэдгээрийг Комиссын дарга томилно.	Дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан иргэний нийгмийн байгууллагыг төлөөлсөн нийт 21 хүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн дарга нь ХЭҮК-ын гишүүн, нарийн бичгийн дарга нь ХЭҮК-ын Тамгын газрын ажилтан байх бөгөөд тэдгээрийг Комиссын дарга томилно.

<p>Зөвлөлийн гишүүнийг томилох</p>	<p>Төрийн бус байгууллагуудаас сонгогдсон нэр дэвшигчийг ХЭҮК-ын хурлаар хэлэлцэн Комиссын даргын тушаалаар томилно.</p> <p>Зөвлөлд мэргэжлийн болон мэргэшсэн байгууллагыг төлөөлөх гишүүдийг Комисс зөвшилцөн холбогдох байгууллагад санал тавьсны дагуу Комиссын дарга шийдвэрлэнэ.</p> <p>Үндэстний болон бэлгийн цөөнх, хорих байгууллага дахь хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын төлөөллийг Комиссын дарга шууд томилно.</p>	<p>Төрийн бус байгууллагуудаас сонгогдсон нэр дэвшигчийг ХЭҮК-ын хурлаар хэлэлцэн Комиссын даргын тушаалаар томилно.</p> <p>Зөвлөлд мэргэжлийн болон мэргэшсэн байгууллагыг төлөөлөх гишүүдийг Комисс зөвшилцөн холбогдох байгууллагад санал тавьсны дагуу Комиссын дарга шийдвэрлэнэ.</p> <p>Үндэстний болон бэлгийн цөөнх, хорих байгууллага дахь хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын төлөөллийг Комиссын дарга шууд томилно.</p>	<p>Төрийн бус байгууллагуудаас сонгогдсон нэр дэвшигчийг ХЭҮК-ын хуралдаанаар хэлэлцэн Комиссын даргын тушаалаар томилно.</p> <p>Зөвлөлд эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоог төлөөлөх гишүүнийг Комисс зөвшилцөн холбогдох байгууллагад санал тавьсны дагуу Комиссын дарга шийдвэрлэнэ.</p> <p>Үндэстний цөөнх, бэлгийн цөөнх, хорих байгууллага дахь хүний эрхийн байгууллагуудын төлөөллийг Комиссын дарга шууд томилно.</p>
<p>Зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх</p>	<p>Гишүүнийг дараах үндэслэлээр чөлөөлнө:</p> <p>1 Эрхэлж буй ажил, албан тушаал өөрчлөгдсөний улмаас ОТБЗ-ийн гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;</p>	<p>Гишүүнийг дараах үндэслэлээр чөлөөлнө:</p> <p>1. Эрхэлж буй ажил, албан тушаал өөрчлөгдсөний улмаас ОТБЗ-ийн гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;</p>	<p>Гишүүнийг дараах үндэслэлээр чөлөөлнө:</p> <p>1. Эрхэлж буй ажил, албан тушаал өөрчлөгдсөний улмаас Зөвлөлийн гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;</p>

	<p>2. Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар ОТБЗ-ийн гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсноос өөрөө хүсэлт гаргасан;</p> <p>3. Томилгооны хугацаа дуусгавар болсон;</p> <p>4. Зөвлөлийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр жилдээ гурваас дээш удаа ирээгүй;</p> <p>5. Комиссын нэрийг өөрийн төлөөлж буй байгууллагын болон хувийн зорилгоор ашиглах, олон нийтийн аливаа арга хэмжээнд Комиссыг төлөөлөн мэдэгдэл хийх зэрэг ёс зүйн алдаа гаргасан нь холбогдох байгууллагаар шалгагдаж тогтоогдсон.</p>	<p>2. Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар ОТБЗ-ийн гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсноос өөрөө хүсэлт гаргасан;</p> <p>3. Томилгооны хугацаа дуусгавар болсон;</p> <p>4. Зөвлөлийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр жилдээ гурваас дээш удаа ирээгүй;</p> <p>5. Комиссын нэрийг өөрийн төлөөлж буй байгууллагын болон хувийн зорилгоор ашиглах, олон нийтийн аливаа арга хэмжээнд Комиссыг төлөөлөн мэдэгдэл хийх зэрэг ёс зүйн алдаа гаргасан нь холбогдох байгууллагаар шалгагдаж тогтоогдсон.</p>	<p>2. Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар Зөвлөлийн гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсноор өөрөө хүсэлт гаргасан;</p> <p>3. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж, шинэ гишүүн томилогдсон.</p> <p>Дараах үндэслэлээр Зөвлөлөөс хасна:</p> <p>1. Зөвлөлийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр жилдээ гурваас дээш удаа ирээгүй;</p> <p>2. Комиссын нэрийг өөрийн төлөөлж буй байгууллагын болон хувийн зорилгоор ашиглах, олон нийтийн аливаа арга хэмжээнд Комиссыг төлөөлөн мэдэгдэл хийх зэрэг ёс зүйн алдаа гаргасан нь холбогдох хууль журмын дагуу шалгагдаж тогтоогдсон.</p>
Хугацаа	3 жил	3 жил	3 жил

**Зөвлөлийн
гишүүний эрх**

1. Комиссоос гарч буй хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, дэмжихтэй холбогдсон бодлогын баримт бичгүүд, үйл ажиллагааны хөтөлбөр, тайлан, төлөвлөгөөний төслийг тухайн төлөөлж буй иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулж санал өгөх;

2. Комиссын явуулж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг тухай бүрт нь авах;

3. Комиссоос иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах чиглэл, арга замын талаар санал гаргах;

4. Комиссоос зохион байгуулж буй бодлогын шинжтэй ажлын талаар төлөөлж буй иргэний нийгмийн байгууллагуудад мэдээлэл хүргүүлж, зохион байгуулахад биечлэн оролцох.

1. Комиссоос гарч буй хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, дэмжихтэй холбогдсон бодлогын баримт бичгүүд, үйл ажиллагааны хөтөлбөр, тайлан, төлөвлөгөөний төслийг тухайн төлөөлж буй иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулж санал өгөх;

2. Комиссын явуулж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг тухай бүрт нь авах;

3. Комиссоос иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах чиглэл, арга замын талаар санал гаргах;

4. Комиссоос зохион байгуулж буй бодлогын шинжтэй ажлын талаар төлөөлж буй иргэний нийгмийн байгууллагуудад мэдээлэл хүргүүлж, зохион байгуулахад биечлэн оролцох.

1. Комиссоос боловсруулсан хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, дэмжихтэй холбогдсон бодлогын баримт бичгүүд, үйл ажиллагааны хөтөлбөр, тайлан, төлөвлөгөөний төсөлд санал өгөх;

2. Комиссын явуулж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг тухай бүрт авах;

3. Комисс болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааны чиглэл, үйл ажиллагааны талаар санал гаргах;

4. Комиссоос зохион байгуулж буй нөлөөлөл, сурталчилгаа, судалгааны болон бодлогын шинжтэй ажилд Комиссын гишүүдийн хуралдаанаас зөвшөөрсөн хэмжээнд оролцох.

Зөвлөлийн гишүүний үүрэг

1. ОТБЗ-д багтдаг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл нь жилд нэг удаа үйл ажиллагааныхаа үр дүнгийн талаар Комиссоос зохион байгуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын уулзалтад тайлагнах;

2. Хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон зайлшгүй судалж, арга хэмжээ авбал зохих асуудлын талаар төлөөлж буй иргэний нийгмийн байгууллагуудаас мэдээллийг тогтмол авч нэгтгэн, Комисст мэдээлэл хүргүүлж ажил хэрэг болгох;

3. Зөвлөлийн гишүүн нь хүний эрхийн анхаарал татсан тодорхой асуудал болон өөрийн салбар дахь хүний эрхийн шинэлэг мэдээллээр Комиссыг хангах;

1. ОТБЗ-д багтдаг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл нь жилд нэг удаа үйл ажиллагааныхаа үр дүнгийн талаар Комиссоос зохион байгуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын уулзалтад тайлагнах;

2. Хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон зайлшгүй судалж, арга хэмжээ авбал зохих асуудлын талаар төлөөлж буй иргэний нийгмийн байгууллагуудаас мэдээллийг тогтмол авч нэгтгэн, Комисст мэдээлэл хүргүүлж ажил хэрэг болгох;

3. Зөвлөлийн гишүүн нь хүний эрхийн анхаарал татсан тодорхой асуудал болон өөрийн салбар дахь хүний эрхийн шинэлэг мэдээллээр Комиссыг хангах;

1. Үйл ажиллагааныхаа үр дүнгийн талаар жил тутам Комиссоос зохион байгуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын уулзалтад тайлагнах;

2. Хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон зайлшгүй судалж, арга хэмжээ авбал зохих асуудлын талаар Комисст тогтмол мэдээлэл хүргүүлж ажиллах;

3. Хүний эрхийн анхаарал татсан асуудал болон өөрийн салбар дахь хүний эрхийн шинэлэг мэдээллээр Комиссыг хангах;

4. Төлөөлж буй иргэний нийгмийн байгууллагыг Комиссын бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах, тэдгээр байгууллагын нийтлэг зорилгыг тууштай илэрхийлэх.

	<p>4. Төлөөлж буй иргэний нийгмийн байгууллагыг Комиссын бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах, тэдгээр байгууллагын нийтлэг зорилгыг тууштай илэрхийлэх;</p> <p>5. Энэхүү дүрэмд заасан эрх, үүргийн хүрээнд идэвх санаачилгатай ажиллах.</p>	<p>4. Төлөөлж буй иргэний нийгмийн байгууллагыг Комиссын бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах, тэдгээр байгууллагуудын нийтлэг зорилгыг тууштай илэрхийлэх;</p> <p>5. Энэхүү дүрэмд заасан эрх, үүргийн хүрээнд идэвх санаачилгатай ажиллах.</p>	
<p>Зөвлөлийн гишүүнд хориглох зүйл</p>	<p>1. Хувийн болон байгууллагынхаа үйл ажиллагаанд Комиссын нэр, таних тэмдэг бүхий гишүүний үнэмлэхийг ашиглах;</p> <p>2. Комиссын үйл ажиллагааны талаар батлагдаагүй, тодорхой бус мэдээллийг олон нийтэд түгээх;</p> <p>3. ОТБЗ-ийн зөвшөөрөлгүйгээр ОТБЗ-ийн байр суурийг олон нийтэд мэдээлэх;</p>	<p>1. Хувийн болон байгууллагынхаа үйл ажиллагаанд Комиссын нэр, таних тэмдэг бүхий гишүүний үнэмлэхийг ашиглах;</p> <p>2. Комиссын үйл ажиллагааны талаар батлагдаагүй, тодорхой бус мэдээллийг олон нийтэд түгээх;</p> <p>3. ОТБЗ-ийн зөвшөөрөлгүйгээр ОТБЗ-ийн байр суурийг олон нийтэд мэдээлэх;</p>	<p>1. Хувийн болон байгууллагынхаа үйл ажиллагаанд Комиссын нэр, таних тэмдэг бүхий Зөвлөлийн гишүүний үнэмлэхийг ашиглах;</p> <p>2. Комиссын үйл ажиллагааны талаар батлагдаагүй, тодорхой бус мэдээллийг олон нийтэд түгээх;</p> <p>3. Зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр Зөвлөлийн байр суурийг олон нийтэд мэдээлэх;</p>

	<p>4. ОТБЗ-ийн үйл ажиллагаа, шийдвэрийг аливаа сонгууль болон бусад зорилгоор улс төрийн хэлбэрээр ашиглах.</p>	<p>4. ОТБЗ-ийн үйл ажиллагаа, шийдвэрийг аливаа сонгууль болон бусад зорилгоор улс төрийн хэлбэрээр үл ашиглах.</p>	<p>4. Зөвлөлийн үйл ажиллагаа, шийдвэрийг аливаа сонгууль болон бусад зорилгоор улс төрийн хэлбэрээр ашиглах.</p>
<p>Ажлын зохион байгуулалт</p>	<p>ОТБЗ жилд дөрвөн удаа хуралдана. ОТБЗ-ийн хурлаас гишүүдийн саналыг үндэслэн тодорхой асуудлаар шийдвэр гарна.</p> <p>ОТБЗ-ийн хурлын шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно.</p> <p>ОТБЗ-ийн шийдвэрийг ОТБЗ-ийн дарга бөгөөд Комиссын гишүүний хэвлэмэл хуудас дээр хэвлэж, ОТБЗ-ийн дарга гарын үсэг зурна.</p> <p>ОТБЗ-ийн хурлын тов, хэлэлцэх асуудлын чиглэлийг хуралдаанаас өмнө ажлын таваас доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргүүлнэ.</p>	<p>ОТБЗ жилд дөрвөн удаа хуралдана. ОТБЗ-ийн хурлаас гишүүдийн саналыг үндэслэн тодорхой асуудлаар шийдвэр гарна. ОТБЗ-ийн хурлын шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно.</p> <p>ОТБЗ-ийн шийдвэрийг ОТБЗ-ийн дарга бөгөөд Комиссын гишүүний хэвлэмэл хуудас дээр хэвлэж, ОТБЗ-ийн дарга гарын үсэг зурна.</p> <p>ОТБЗ-ийн хурлын тов, хэлэлцэх асуудлын чиглэлийг хуралдаанаас өмнө ажлын таваас доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргүүлнэ.</p>	<p>Зөвлөл жилд дөрвөн удаа хуралдана. Зөвлөлийн хурлын шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно.</p> <p>Зөвлөлийн шийдвэрийг Зөвлөлийн дарга бөгөөд Комиссын гишүүний хэвлэмэл хуудас дээр хэвлэж, Зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. Зөвлөлийн шийдвэрийг Комиссын хуралдаанд танилцуулж, шаардлагатай тохиолдолд зохих шийдвэр гаргуулна.</p> <p>Зөвлөлийн хурлын тов, хэлэлцэх асуудлын чиглэлийг хуралдаанаас өмнө ажлын таваас доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргүүлнэ.</p>

	<p>Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ОТБЗ-ийн ээлжит бус хурлыг ОТБЗ-ийн гишүүдийн олонхын санаачилгаар ОТБЗ-ийн дарга зарлан хуралдуулж болно.</p> <p>ОТБЗ нь Комиссын стратеги төлөвлөгөө, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.</p>	<p>Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ОТБЗ-ийн ээлжит бус хурлыг ОТБЗ-ийн гишүүдийн олонхын санаачилгаар ОТБЗ-ийн дарга зарлан хуралдуулж болно.</p> <p>ОТБЗ нь Комиссын стратеги төлөвлөгөө, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.</p>	<p>Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Зөвлөлийн ээлжит бус хурлыг Зөвлөлийн гишүүдийн олонхын санаачилгаар Зөвлөлийн дарга зарлан хуралдуулж болно.</p> <p>Зөвлөл нь Комиссын стратеги төлөвлөгөө, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.</p>
<p>Хурлын дэг</p>	<p>ОТБЗ-ийн хурлыг ОТБЗ-ийн дарга даргалж, зөвлөлийн гишүүд ээлжлэн чиглүүлнэ. Зөвлөлийн гишүүд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд хуралд заавал оролцоно.</p>	<p>ОТБЗ-ийн хурлыг ОТБЗ-ийн дарга даргалж, зөвлөлийн гишүүд ээлжлэн чиглүүлнэ. Зөвлөлийн гишүүд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд хуралд заавал оролцоно.</p>	<p>Зөвлөлийн хурлыг Зөвлөлийн дарга даргалж, хуралдуулна. Зөвлөлийн гишүүд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд хуралд заавал оролцоно.</p>

Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт	ОТБЗ-ийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг Комиссын жилийн төсөвт тусгана. Комиссоос зохион байгуулж буй гадаад, дотоодын арга хэмжээнд Зөвлөлийн гишүүдийг оролцуулна.	ОТБЗ-ийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг Комиссын жилийн төсөвт тусгана. Комиссоос зохион байгуулж буй гадаад, дотоодын арга хэмжээнд Зөвлөлийн гишүүдийг оролцуулна.	Зөвлөлийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг Комиссын жилийн төсөвт тусгана.
Хурлын явцыг баримт- жуулах, архивлах журам	Дүрэмд тусгасан.	Дүрэмд тусгасан.	Дүрэмд тусгасан.

Харьцуулалтаас үзэхэд, Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Зөвлөлийн дүрэм хэд хэдэн удаа батлагдаж хэрэгжсэн байна. Эдгээр дүрэмд тус Зөвлөлийн бүрэлдэхүүн, Зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх, гишүүний бүрэн эрхийн хугацаа, Зөвлөлийн гишүүний эрх, үүрэг, Зөвлөлийн гишүүнд хориглох зүйл, Зөвлөлийн ажлын зохион байгуулалт, хурлын дэг, явцыг баримтжуулах, архивлах журам, Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт болон тус дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөлийг нэг ижил байдлаар буюу агуулгын ялгаагүйгээр тусгажээ.

Харин Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн А/06 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн дүрэм”-ийн 1.5-д иргэний нийгмийн байгууллага гэдэгт дараах бүлэг, чиглэлийн хүрээнд ажилладаг үндэсний болон олон улсын хүний эрхийн төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, сан болон мэргэжлийн холбоодыг ойлгоно гэж зааснаар өмнөх дүрмүүдээс ялгарч байна. Тухайлбал, хүүхэд; эмэгтэйчүүд; эрэгтэйчүүд; залуучууд; ахмад настан; эрүүл мэнд; хөгжлийн бэрхшээлтэй хүн; байгаль орчин-уул уурхай; шашин; олон улсын байгууллага; үндэстний цөөнх; бэлгийн цөөнх; хорих байгууллага дахь хүний эрх;

Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо; Монголын Ажил олгогч эздийн холбоо; Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл; Монголын Хуульчдын холбоо; Монголын Өмгөөлөгчдийн холбоо; Монгол Улсын Шинжлэх ухааны академи гэж жагсаасан байна.

Комиссын гишүүний нэгэн бүрэн эрхийн хугацаа зургаан жил байх зохицуулалт өөрчлөгдөөгүй хэдий ч Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацааг урьдын адил гурван жил байхаар тогтоосон нь Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүнээр ажиллах боломжийг хүний эрхийн шинжээч, мэргэжилтнүүдэд олгоход түлхүү чиглэсэн гэж үзэж болох юм. Гэвч энэ зохицуулалт Зөвлөлийн гишүүдийн мэргэшиж ажиллахад сөргөөр нөлөөлөх, Комисстой хамтран ажиллах урт хугацааны төлөвлөгөөг тасалдуулахад хүргэх сул талтай байж болохоор байна.

Зөвлөлийн дарга нь Комиссын гишүүн байх, Зөвлөлийн шийдвэрийг Зөвлөлийн дарга бөгөөд Комиссын гишүүний хэвлэмэл хуудас дээр хэвлэж, Зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулах зохицуулалт нь Зөвлөл өөрөө Комиссоос хараат бус байх, идэвх санаачилгатай ажиллахад сөргөөр нөлөөлөх сул талтай байж болохоор юм. Зөвлөлийн хувьд Комиссын гишүүнээс үл хамааран санаачилгаараа тогтмол идэвхтэй ажиллах буюу хүний эрхийн шинжээчийн хувиар ажиллах нөхцөлийг холбогдох дүрэмд тусгах нь зүйтэй.

Дээрх дүрмүүдээс гадна Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/24 дүгээр тушаалын хавсралтаар “Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын орон тооны бус зөвлөхийн ажиллах журам” батлагдсан байх бөгөөд тус журмын 2.1.2-т “Хүний эрхийн асуудлаар мэргэшсэн, хүний эрхийг хамгаалах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагын удирдах албан тушаалтныг Хүний эрхийн Үндэсний Комиссын хуралд танилцуулж, Комиссын даргын тушаалаар нэг жилийн хугацаагаар томилно”, 3.1.1-д зааснаар зөвлөхийн хувьд “Комиссын даргыг шаардлагатай мэдээллээр хангаж, хүний эрхийн асуудлаар бодлогын зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлнэ” гэснээс харахад Орон тооны бус зөвлөл ба Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын орон тооны бус зөвлөхийн үйл ажиллагаанд давхцал үүсэх, зөвлөл ба зөвлөхийн үйл ажиллагаа хэрхэн уялдах нь тодорхойгүй байдалд хүрэх зохицуулалт болсон нь харагдаж байна.⁶⁰ Иймд

⁶⁰ Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2017.12.19-ний өдрийн “Журам батлах тухай” Б/24 дүгээр тушаалын хавсралт, “Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын орон тооны бус зөвлөхийн ажиллах журам”, <https://bit.ly/3lHrUAm>

Зөвлөлийн болон түүний гишүүдийн үйл ажиллагааг сулруулах, идэвхгүй болгох үр дагавартай нэмэлт бүтэц, нэгж байгуулахгүй байхад анхаарах шаардлагатай.

2.2.4. Орон тооны бус зөвлөл, Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүнээр ажилласан хүний эрхийн шинжээчид

2011 оны 3 дугаар сард Хүний эрхийн Үндэсний Комиссын Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан бөгөөд хүний эрхийн дараах шинжээчид сонгогджээ.⁶¹ Үүнд:

1. “Ч.Галсан сан”-гийн тэргүүн Г.Галтайхүү
2. Глоб Интернэшнл төв ТББ-ын тэргүүн Х.Наранжаргал
3. Иргэдийн Альянс төвийн тэргүүн Ж.Занаа
4. Казах эмэгтэйчүүдийн “Арулар” холбооны тэргүүн С.Айнагүл
5. ЛГБТ нөлөөллийн хөтөлбөрийн менежер Ц.Отгонбаатар
6. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар
7. Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч С.Ганбаатар
8. Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Д.Баатаржав
9. Монголын Эмэгтэйчүүдийн сангийн гүйцэтгэх захирал Н.Чинчулуун
10. Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэг
11. Нээлттэй Нийгэм Форум ТББ-ын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал
12. Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэгийн тэргүүн Б.Мөнхжаргал
13. Үндсэн уртраг ТББ-ын тэргүүн О.Цэндбаатар
14. Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн тэргүүн Л.Эрдэнэчулуун
15. Хүний эрх, ардчиллын судалгааны төвийн тэргүүн С.Цэрэндорж
16. Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож
17. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн гүйцэтгэх захирал Д.Энхжаргал
18. Экпат сүлжээний зохицуулагч Д.Энхбат
19. Эмнести интернэшнл байгууллагын гүйцэтгэх захирал Б.Алтантуяа

⁶¹ Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын 2021.06.04-ний өдрийн мэдээлэл.

2014 онд Хүний эрхийн Үндэсний Комиссын Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэгдсэн бөгөөд түүнд хүний эрхийн дараах шинжээчид оржээ. Үүнд:

1. “Ч.Галсан сан”-гийн тэргүүн Г.Галтайхүү
2. Иргэдэд туслах хүний эрхийн төвийн тэргүүн С.Дондов
3. Казах эмэгтэйчүүдийн “Арулар” холбооны тэргүүн С.Айнагүл
4. ЛГБТ төвийн Гүйцэтгэх захирал Н.Анараа
5. МАОЭНХ-ны ерөнхийлөгчийн зөвлөх Д.Нармандах
6. Монгол Улсын ШУА-ийн дэд ерөнхийлөгч, академич Т.Дорж
7. Монголын ахмадын чөлөөт холбооны нийслэлийн тэргүүн Ч.Дариймаа
8. Монголын бурхан, шашны төв Гандантэгчинлэн хийдийн Да лам Х.Бямбажав
9. Монголын залуучуудын холбооны бодлого төлөвлөлтийн газрын дарга С.Болорцэцэг
10. Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч Б.Галаарид
11. Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны дэд ерөнхийлөгч С.Эрдэнэбат
12. Монголын эрэгтэйчүүдийн холбооны тэргүүн, хошууч генерал Я.Пүрэвдорж
13. “Оюу Толгойн хяналт” ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Сүхгэрэл
14. Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч Д.Баатаржав
15. Хүний аюулгүй байдал судалгааны төвийн тэргүүн Л.Эрдэнэчулуун
16. Хүний хөгжил, нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрх ТББ-ын ерөнхий зохицуулагч Б.Алтанчимэг
17. Хүүхдийн эрх хамгаалал төвийн захирал Л.Бадамцэцэг
18. Шихихутуг ХЗС-ийн багш Р.Оюунбадам
19. Эмнести интернэшнл байгууллагын гүйцэтгэх захирал Б.Алтантуяа

Иргэний нийгмийн зөвлөлийн бүрэлдэхүүн 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар хүний эрхийн төрөл тус бүрийн төлөөлөл болох дараах 19 шинжээчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Үүнд:

1. Хүүхдийн эрх: Б.Жавзанхүү (Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны төвийн захирал)

2. Эмэгтэйчүүдийн эрх: Б.Золзаяа (Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд ТББ-ын захирал)
3. Эрэгтэйчүүдийн эрх: М.Чинзориг (Монголын Эрэгтэйчүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн)
4. Залуучуудын эрх: Ч.Ундрах (Гүнж төвийн захирал)
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх: Д.Гэрэл (Монголын Хараагүйчүүдийн холбооны ерөнхийлөгч)
6. Эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрх: Д.Мягмардорж (Залуу, эрүүл мэнд төв ТББ-ын гүйцэтгэх захирал)
7. Байгаль орчин, уул уурхай ба хүний эрх: Д.Эрдэнэчимэг (Нээлттэй Нийгэм Форум ТББ-ын менежер)
8. Ахмад настны эрх: П.Бямбацэрэн (Монголын ахмадын холбооны дэд ерөнхийлөгч, АА-ын дарга)
9. Боловсрол ба хүний эрх: Д.Тунгалаг (“Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч)
10. Үндэстний цөөнхийн эрх: С.Айнагүл (Казах эмэгтэйчүүдийн “Арулар” холбооны тэргүүн)
11. Үндэстний цөөнхийн эрх: Г.Галтайхүү (“Галсан” сангийн тэргүүн)
12. ЛГБТ хүмүүсийн эрх: Д.Мөнхтуяа (ЛГБТ төвийн гүйцэтгэх захирал)
13. Хорих байгууллага дахь хүний эрх: Б.Алтантуяа (Монголын Эмнести интернэшнл байгууллагын гүйцэтгэх захирал)
14. Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо: Ц.Отгонтунгалаг (МҮЭ-ийн хөдөлмөр, нийгмийн бодлогын газрын дарга)
15. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо: Д.Нармандах (МАОЭНХ-ны ерөнхийлөгчийн зөвлөх)
16. Эрдэм шинжилгээний байгууллага: Б.Баярт (ШУА-ийн дэд ерөнхийлөгч, академич)
17. Хэвлэл мэдээлэл ба хүний эрх: Х.Батхишиг (Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн дэд ерөнхийлөгч)
18. Шашны байгууллага: С.Дэмбэрэл (МУИС-ийн ШУС-ийн философи, шашин судлалын тэнхимийн багш)
19. Олон улсын байгууллага: С.Цэцгээ (“Дэлхийн зөн–Монгол” ОУБ-ын менежер)

Эндээс харахад, Үндэстний цөөнхийн эрхийн шинжээч болох “Ч.Галсан” сангийн тэргүүн Г.Галтайхүү, Казах эмэгтэйчүүдийн “Арулар” холбооны тэргүүн С.Айнагүл, Хорих байгууллага дахь хүний эрхийн шинжээч болох Монголын Эмнести интернэшнл байгууллагын гүйцэтгэх захирал Б.Алтантуяа нар тус бүр гурван удаа буюу тасралтгүй, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч Д.Баатаржав, Хүний аюулгүй байдал судалгааны төвийн тэргүүн Л.Эрдэнэчулуун нар тус бүр хоёр удаа Хүний эрхийн Үндэсний Комиссын Орон тооны бус зөвлөл болон Иргэний нийгмийн зөвлөлд гишүүнээр ажиллажээ.

Тус судалгааны зорилго, агуулгыг танилцуулсны дагуу дээрх зөвлөлд олон жил тогтвортой ажилласан хүний эрхийн шинжээчтэй Хүний эрхийн Үндэсний Комиссын Орон тооны бус зөвлөл, Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүнээр ажиллахын давуу, сул тал болон тус Зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, ажлынх нь үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарах зүйлийн талаар ярилцсан бөгөөд хүний эрхийн шинжээчээс дараах хариултыг өгсөн болно. Үүнд:

а) Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд иргэний нийгмийн байгууллагын бүтэц бий болгосон нь маш том ололт. Энэ бүтэцтэй байсны давуу талыг дараах байдлаар тодорхойлж болно:

- Иргэний нийгмийн туслалцаа, дэмжлэгийг бодлого, стратеги, мониторинг гээд бүх чиглэлээр авах боломж бүрдэх;*
- Хүний эрхийн Үндэсний Комиссын тэргүүлэх чиглэл, зорилго, зорилтыг бусадтай хуваалцаж, нөөц хүчийг дайчлах боломж бий болох;*
- Цаг үеийн тулгамдсан, эсхүл хурцадмал байдлын үед шинжээчийн дэмжлэг авах;*
- Иргэдтэй ойлголцох гүүр болгох;*
 - Хүний эрхийн зөрчил, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх;*
 - Мэдээлэл түргэн шуурхай солилцох;*
 - Хохирогч хамгаалал дээр шуурхай дэмжлэг авах.*

Гэхдээ Хүний эрхийн Үндэсний Комисс нь уг бүтцийнхээ үзэл баримтлалыг бүрэн ойлгоогүйгээс үр дүнтэйгээр ажиллуулж чаддаггүй гэж дүгнэж болно. Өөрөөр хэлбэл, Комисс уг бүтцэд онцгой ач холбогдол өгдөггүй, Хүний эрхийн Үндэсний Комиссын санаачилгаар үр дүнтэй хамтран, эсхүл чиглүүлэн, манлайлан ажиллуулж чаддаггүй байсан. Харин эсрэгээр тус бүтцэд орсон

ТББ-ын төлөөлөл нь уг бүтцийг үр дүнтэй ашиглаж, дуу хоолойгоо уг бүтцээр дамжуулан хүргэдэг байсан нь өнөөг хүртэл энэ бүтэц тогтож, хадгалагдан, бага ч гэсэн хувь нэмрээ оруулахад хүргэсэн. Ийм бүтэц, механизм байх нь хүний эрхэд тустай гэж үзсэн учраас ийн туршлагажсан төрийн бус байгууллагуудын төлөөллөөс Хүний эрхийн Үндэсний Комиссын орон тооны бус зөвлөлийг иргэний нийгмийн зөвлөл болгох, илүү мэргэжлийн, судалгаанд суурилсан алсын хараатай, чадавхтай багаар бүрдүүлэхэд анхаарч төрийн бус байгууллагаас сонгогдох төлөөлөлд тодорхой шалгуур тавихыг шаардаж, санал болгох зэргээр Орон тооны бус зөвлөлийг хөгжлийн дараагийн шатанд нь гаргасан. Гэвч Хүний эрхийн Үндэсний Комисс өнөөх л ач холбогдол өгдөггүй хэвээр өнөөг хүртэл иргэний нийгмийн зөвлөлийг бүрэн утгаар нь ажиллуулж, дэмжлэгийг нь бүрэн авч чадахгүй л байна.

- б) Зөвлөл нь тогтмол уулзалт, хуралдаан хэлбэрээр ажилладаг хэв шинжтэй тул эдгээр хуралдааныг үр дүнтэй хийх нь чухал байдаг. Гэтэл оролцоог хязгаарласан зохион байгуулалт болон тухайн хурал удирдагчийн хүсэл зоригоос хамаараад уг Зөвлөлийн хурал оролцоог ёс төдий хангадаг байсан. Хэлэлцүүлэг өрнүүлэх, стратеги бодлогын хэлэлцүүлэгт татан оролцуулах, мониторинг болоод зөрчлийн баримт мэдээлэлд дайчлах тал дээр ихээхэн дутмаг. Энэ нь уг Орон тооны бус зөвлөл, Иргэний нийгмийн зөвлөлийн эрх зүйн орчин хангалтгүй байгаагийнх бус гол нь тухайн хурал даргалагч, Хүний эрхийн Үндэсний Комиссын хүсэл зориг, зохион байгуулалттай холбоотой асуудал юм. Зөвлөлийн гишүүдийг оролцогч биш зөвхөн сонсогч болгосон, мөн хурал, уулзалтын хөтөлбөрийг цагийг нь тулгаж ирүүлдэг бөгөөд цахимаар оролцох бололцоог техникийн хувьд хангаж өгдөггүй байсан болно.

Тус Зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэхэд шаардлагатай, цаашид анхаарах зүйлийг дурдвал:

- Иргэний нийгмийн зөвлөлийн бүтцэд гишүүн сонгон шалгаруулахдаа анхаарах, шалгуурыг ягштал баримтлах;
- Илүү утга учиртай, бодитой оролцоо, хэлэлцүүлэг бий болгох, оролцоо санаачилгыг нь дэмжих, тухайлан мэдээлэл солилцох тогтмол суваг, дэд бүтэц бий болгох;
- Хүний эрхийн Үндэсний Комисс илүү идэвх санаачилгатай, манлайлж ажиллах;

- Хүний эрхийн Үндэсний Комисс нь тухайн хүнийг, эсхүл тухайн иргэний нийгмийн байгууллагыг үйл ажиллагаанд шинжээчээр татан оруулах бол холбогдох зардлыг хариуцах, хөрөнгө оруулах. Ийм зүйл байдаггүйгээс Комисс зөвхөн төсөл хөтөлбөртэй эсхүл чадавхтай олон улсын байгууллагатай л ажиллахад хүрдэг. Гэтэл орон нутгийн хэмжээнд шинжээч хэрэг болох үед зардлаас болоод мэргэшсэн шинжээчийг дайчилдаггүй, идэвх оролцоог нь сулруулдаг;
- Зөвлөлийн гишүүний ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг журамдаа нарийвчлан тусгах, ийнхүү заагүйгээс уг Зөвлөлд багтсан гишүүд Хүний эрхийн Үндэсний Комиссын нэр хүндийг урвуулан ашиглах эрсдэл өндөртэй;
- Тусгайлсан бүтэц, механизм хэмээн үзэж цахим хуудсандаа байрлуулах, хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийг олон нийтэд мэдээлж байх, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлснээ эргэн тайлагнаж байх.

Эндээс харахад, Орон тооны бус зөвлөлийг Комиссын гишүүн даргалж, Зөвлөлийн шийдвэрийг Комиссын гишүүний хэвлэмэл хуудсан дээр гаргадаг зэргээр Комиссын гишүүний оролцоогүйгээр тус Зөвлөлийн үйл ажиллагаа явах нөхцөл хязгаарлагдмал, улмаар тус Зөвлөлийн үйл ажиллагаа Комиссын гишүүний идэвх, чармайлтаас хамаарч байсныг анхаарч, өөрчлөх нь зүйтэй.

Сүүлийн жилүүдэд төрийн бус байгууллагууд хүний эрхийн чиглэлээр НҮБ-ын хүний эрхийн механизмыг үр дүнтэй ашиглах чиглэлээр чадавхжиж, туршлага хуримтлуулаад байгаа билээ. Тухайлбал, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR)-ийн механизмд Монголын хүний эрхийн ТББ-уудын форум 2010, 2015, 2020 онд тус тус оролцож, хүний эрхийн асуудлаар 30 гаруй тайлан бичиж илгээжээ.⁶² Тус Форум нь 50 орчим ТББ-ыг эгнээндээ нэгтгэсэн сайн дурын сүлжээ юм. Энэ нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах хүний эрхийн шинжээчдийн нөөц шавхагдаагүй буюу хангалттай байгааг батлан харуулж байна. Иймд Иргэний нийгмийн зөвлөлд ажиллах хүний эрхийн шинжээчийг сонгохдоо урьд нь тус Зөвлөлд ажилласан эсэхийг харгалзан үзэх шаардлагатай.

⁶² www.upr-mongolia.mn, www.ohchr.org

III. Дүгнэлт, зөвлөмж

Хүний эрхийг хамгаалах, дэмжихэд нэг чухал оролцогч нь иргэний нийгмийн байгууллага бөгөөд Хүний эрхийн Үндэсний Комисс түүнтэй нягт, идэвхтэй хамтран ажиллах шаардлагатайг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 48/134 тоот тогтоолоор баталсан Хүний эрхийн үндэсний байгууллагуудын эрх зүйн байдлын талаарх зарчим буюу Парисын зарчимд онцолсон билээ.

Парисын зарчмын энэ шаардлагыг НҮБ-ын хэмжээнд байнга нотолж байна. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаас 2018 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд; 2019, 2020 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейд танилцуулсан холбогдох тайландаа “Хүний эрхийн үндэсний байгууллагууд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлж, түүнийгээ албан ёсны болгон хадгалж, хүний эрхийг сурталчлах, хамгаалах чадавхыг бэхжүүлэх шаардлагатай” талаар сануулсан байна.

Харин Хүний эрхийн Үндэсний Комисс ба иргэний нийгмийн байгууллага хоорондоо хэрхэн хамтран ажиллах загварыг “НҮБ болон төрийн бус байгууллагууд хоорондын зөвлөлдөх харилцааны тухай” НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1996/31 тоот тогтоолоор тогтоожээ. Энэхүү загварыг Хүний эрхийн Үндэсний Комисс ба иргэний нийгмийн байгууллага хоорондын хамтын ажиллагаанд хэрэглэж байгааг бусад улсын хууль тогтоомж, практикаас харж болох юм. Энэ нь Монгол Улсын нөхцөлд олон улсын эрх зүйн дээрх зарчим, жишгийг баримтлан Иргэний нийгмийн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах боломжтойг харуулж байна.

Парисын зарчим, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн тогтоосон загварын дагуу Хүний эрхийн үндэсний байгууллага дэргэдээ иргэний нийгмийн байгууллагын бүтцийг ажиллуулах жишиг тогтжээ. Тухайлбал Шри Ланка, БНСУ, ОХУ, Австри, Бүгд Найрамдах Эстони зэрэг улсын хүний эрхийн үндэсний байгууллагын дэргэд “Хүний эрхийн дэд хороо”, “Хүний эрхийн зөвлөх зөвлөл”, “Хүний эрхийн шинжээчийн зөвлөл”, “Хүний эрхийн асуудлаарх зөвлөх хороо” ажиллаж байна. Эдгээр зөвлөл, хороог Хүний эрхийн үндэсний байгууллага өөрөө байгуулж, холбогдох бүрэлдэхүүнийг баталж, үйл ажиллагааг нь зохицуулдаг.

Монгол Улсын хувьд төрийн тодорхой байгууллагын дэргэд иргэний нийгмийн байгууллагыг оролцуулсан буюу түүний оролцоог хангах “олон нийтийн хяналт”-ыг хэрэгжүүлэх бүтцийн талаар хууль тогтоомждоо тусгаж буй жишиг тогтсон. Харин Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөл, Иргэний нийгмийн зөвлөлийн хувьд олон нийтийн хяналт тавих бус Комисст туслах, дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэ нь Орон тооны бус зөвлөл, Иргэний нийгмийн зөвлөлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын гол хамтрагч, түншлэгч гэж үзэж байгааг батлан харуулж байна.

Монгол Улсын хуулиар тогтоосон “төрийн бус байгууллагуудыг хүний эрхийн салбарт ажиллах механизм бүрдүүлэх, иргэний нийгмийн байгууллагуудыг Хүний эрхийн Үндэсний Комисстой байнга хамтарч ажиллах” үзэл баримтлалын тодорхой илэрхийлэл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөл, Иргэний нийгмийн зөвлөл байх бөгөөд хуульд тус зөвлөлийн ерөнхий чиг үүргийг товч тусгасан. Хэдий тийм боловч дагалдах олон нөхцөлийг зохицуулалтгүй орхигдуулсан тул тэдгээр нөхцөлийг Хүний эрхийн Үндэсний Комисс бие даан тодорхойлох жишиг бий болжээ. Нөгөө талаар, энэ байдал нь Иргэний нийгмийн зөвлөлийг бүрдүүлэх, ажиллуулах уян хатан арга, хэлбэрийг хуулиар хязгаарлаагүй, нээлттэй үлдээсний үр дагавар гэж үзэж болох юм. Өнгөрсөн хугацаанд Хүний эрхийн Үндэсний Комисс ба Орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны хүрээ, арга барил нэгэнт тогтжээ. Харин тэрхүү үйл ажиллагаа нь Хүний эрхийн Үндэсний Комиссын идэвх, санаачилгаас илүү хамааралтай болсон байна.

Дээр дурдсан нөхцөл байдал, олон улсын жишиг, бусад улсын туршлагад нийцүүлэн Хүний эрхийн Үндэсний Комисс, Иргэний нийгмийн зөвлөлийн үйл ажиллагааг үр нөлөөтэй байлгахын тулд Комиссоос батлах дүрэмд дараах асуудлыг тусгах нь зүйтэй. Үүнд:

- Иргэний нийгмийн зөвлөлийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тогтоох. Энэ хүрээнд Комиссын үйл ажиллагааны үндсэн зарчмыг Иргэний нийгмийн зөвлөлийн үйл ажиллагаанд нэгэн адил баримтлах;
- Иргэний нийгмийн зөвлөлөөс дараах дэмжлэгийг Комисст хариу төлбөргүй үзүүлэх:
 - о хүний эрхийн асуудлаар шинжээчийн дүгнэлт гаргах;
 - о хүний эрхийн зөрчлөөс сэрэмжлүүлэх;
 - о хүний эрхийг хамгаалах, дэмжихтэй холбоотой баримт бичгүүдэд

мониторинг хийх, тэдгээр баримт бичгийг боловсронгуй болгоход чиглэсэн санал гаргах, түүнийг хэрэгжүүлэхэд туслах;

- о Комиссын зорилго, чиг үүрэг, гомдол шийдвэрлэх талаарх ойлголт, мэдлэг түгээх сүлжээ бий болгох замаар хүний эрхийг хамгаалах, дэмжих асуудлаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхэд туслах;
 - о Комиссыг чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай мэдээллээр хангах;
 - о Комисст гомдол гаргах асуудлаар хохирогчид дэмжлэг үзүүлэх;
- Комисс нь сонгон шалгаруулалтын үндсэн дээр хүний эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр олон нийтэд болон тухайн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн этгээдийг Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүнээр холбогдох баримт бичгийг үндэслэн томилох;
 - Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүнээр сонгогдох этгээд нь тухайлан итгэмжлэл олгосноос бусад тохиолдолд төрийн бус болон бусад байгууллагыг төлөөлөхгүй, зөвхөн Зөвлөлийн үйл ажиллагаанд хүний эрхийн шинжээчийн хувиар оролцох;
 - Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүнийг томилох, түдгэлзүүлэх, чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг үндэслэн Комиссын хуралдаанаар шийдвэрлэх, тийнхүү түдгэлзүүлэх, чөлөөлөх шийдвэр гаргахаас өмнө Зөвлөлийн гишүүн эс зөвшөөрч хариу тайлбар гаргах боломжтой байх;
 - Комиссоос дэмжлэг шаардлагатай үйл ажиллагааны талаар Зөвлөлд буюу түүний гишүүнд тухай бүр мэдэгдэх;
 - Зөвлөлөөс өөрийн санаачилгаар Комисст дэмжлэг үзүүлэх тодорхой саналаа Зөвлөл хариуцсан Комиссын гишүүн буюу Комиссын Тамгын газрын даргаар дамжуулан мэдэгдэж болох;
 - Зөвлөлөөс түүнийг төлөөлөх гишүүнийг Комиссын нээлттэй хуралдаанд ажиглагчаар оролцуулж болох. Зөвлөлөөс төлөөлөгчөөр ажиллуулах гишүүн нь Комиссын тухайн хуралдаанд хэлэлцэж буй асуудлаар мэргэшсэн, туршлагатай гишүүн байвал зохих;
 - Зөвлөл, түүний гишүүнээс гаргасан дүгнэлт, саналыг Комисс үйл ажиллагаандаа заавал тусгах үүрэггүй ч тусгаагүй шалтгаан, үндэслэлээ тайлбарладаг байх тухай холбогдох баримт бичиг, шийдвэрт тусгах;

- Зөвлөлийн дотоод үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь ээлжит болон ээлжит бус хурал байх. Хурлаас гарах шийдвэр, мэдээллийг бичгээр үйлдэх бөгөөд Комисст хандсан шийдвэр нь зөвлөмж хэлбэртэй байх;
- Зөвлөлийн ээлжит хурлыг улиралд нэгээс доошгүй удаа Зөвлөлийн даргын зарласнаар, ээлжит бус хурлыг Комиссын даргын хүсэлтээр болон Зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар зарлан хуралдуулах;
- Комиссын Тамгын газраас Зөвлөлийн хурлыг зохион байгуулахтай холбоотой бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Зөвлөл нь хүний эрхийн асуудал эрхэлсэн ашгийн төлөө бус хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн багш, судлаачийг оролцуулсан олон талт төлөөлөл бүхий 15-аас доошгүй тооны гишүүнтэй байх, Зөвлөлийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Комиссын хуралдаанаас зургаан жилийн хугацаагаар томилох;
- Зөвлөлөөс жил бүр үйл ажиллагааны тайлан гаргаж тухайн оны 1 дүгээр сард багтаан Комиссын Тамгын газраар дамжуулан Комиссын гишүүдэд хүргүүлэх, Зөвлөлийн тайланг олон нийтэд мэдээлэх.

Үүнтэй холбоотойгоор “Иргэний нийгмийн зөвлөлийн дүрмийн загвар төсөл”-ийг боловсруулж хавсралтаар оруулав (Хавсралт 2-ыг үзнэ үү).

Хавсралт

Хавсралт 1. Иргэний нийгмийн байгууллагын оролцооны талаарх хуулийн зохицуулалтын түүвэр

	Хуулийн нэр	Огноо	Зохицуулалтын агуулга
1	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	1995.03.30	<p>32 дугаар зүйл.Байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох</p> <p>1. Байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллага болон байгалийн нөөцийн хамтын менежмент эрхлэн явуулах нөхөрлөл байгаль орчныг хамгаалах талаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:</p> <p>1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;</p> <p>2/ байгаль орчныг хамгаалах талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллага болон зохих шатны Хурал, Засаг даргад уламжлах;</p> <p>3/ экологийн сургалт, хүмүүжлийн ажлыг өөрөө болон холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;</p> <p>4/ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, зөвлөмж, аргачлал боловсруулж холбогдох байгууллагад танилцуулж шийдвэр гаргуулах.</p>
2	Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль	1997.10.23	<p>6.1. Орчны бүсийн хөгжлийг зохицуулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд нутгийн иргэдийн оролцоог өргөжүүлэх зорилго бүхий орон тооны бус орчны бүсийн зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ ажиллана.</p> <p>6.4. Зөвлөл дараах эрх, үүрэгтэй:</p> <p>6.4.1. тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсэд хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих.</p>

3	Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль	2000.02.03	6.4. Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд төрийн бус байгууллага, хувь хүн хуулиар тогтоогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд олон нийтийн хяналт тавьж, санал, хүсэлтээ төрийн холбогдох байгууллагад гаргаж болно.
4	Олон нийтийн радио, телевизийн тухай хууль	2005.01.27	21 дүгээр зүйл. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, түүнийг томилох: Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл 15 гишүүнтэй байна. Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. Үндэсний зөвлөлийн гишүүнээр ял шийтгэлгүй, иргэний нийгмийн төлөөллөөс санал болгосон Монгол Улсын иргэнийг томилно. Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлнэ: 1. Монгол Улсын Ерөнхийлөгч 4 хүн; 2. Монгол Улсын Их Хурал 7 хүн; 3. Монгол Улсын Засгийн газар 4 хүн. Төрийн бус байгууллагууд тухайн ... чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг холбогдох этгээдэд тус тус санал болгоно.
5	Сонгуулийн төв байгууллагын тухай хууль	2006.0.12	14 дүгээр зүйл. Хэвлэл мэдээллийн зөвлөл 14.1. Хороо сонгуулийн үеэр дэргэдээ хараат бус хэвлэл мэдээллийн орон тооны бус зөвлөл байгуулж ажиллуулна. 14.2. Хэвлэл мэдээллийн зөвлөл нь хэвлэл, мэдээллийн мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөл болон сонгуульд оролцож буй нам, эвслийн тэгш төлөөллөөс бүрдсэн байна. 14.3. Хэвлэл мэдээллийн зөвлөл нь нам, эвсэл, нэр дэвшигчийн хэвлэл мэдээллийн сурталчилгааны тэнцвэрт байдалд хяналт тавих бөгөөд энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, хуулийн этгээд, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж, санал дүгнэлт гаргаж Хороонд танилцуулна. 14.4. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Хороо тогтооно.

6	Авлигын эсрэг хууль	2006.07.06	<p>27 дугаар зүйл. Олон нийтийн зөвлөл</p> <p>27.1. Авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зөвлөмж өгөх зорилго бүхий орон тооны бус олон нийтийн зөвлөл Авлигатай тэмцэх газрын дэргэд ажиллана.</p> <p>27.2. Олон нийтийн зөвлөл 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба Зөвлөлийн гишүүнээр ял шийтгэлгүй, иргэний нийгмийг төлөөлөх иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч 4 жилийн хугацаагаар томилно.</p> <p>27.3. Олон нийтийн зөвлөлийн гишүүнд төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагчийг нэр дэвшүүлэхгүй.</p> <p>27.4. Олон нийтийн зөвлөлийн гишүүн Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд хамаарах нууцыг задруулахыг хориглоно.</p> <p>27.5. Олон нийтийн зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.</p>
7	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	2008.05.22	<p>34 дүгээр зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар тавих олон нийтийн хяналт</p> <p>34.1. Ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах болон төрийн бус байгууллага нь олон нийтийн хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:</p> <p>34.1.1. үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын талаар үнэн зөв мэдээлэл авах;</p> <p>34.1.2. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн зөрчлийг арилгах шаардлагыг ажил олгогчид тавих;</p> <p>34.1.3. хөдөлмөрийн болон хамтын гэрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар хүлээсэн үүргийн биелэлт, түүний явцыг дүгнэж, нийт ажилтанд мэдээлэх;</p> <p>34.1.4. үйлдвэрлэлийн барилга байгууламж, машин механизм, тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авах, туршилт хийх комиссын бүрэлдэхүүнд оролцох;</p>

			<p>34.1.5. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулахад оролцох, санал өгөх;</p> <p>34.1.6. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, хөдөлмөрийн болон хамтын гэрээ, хэлэлцээрт тусгагдсан асуудлаар үүссэн маргааныг хэлэлцэх, шийдвэрлэхэд оролцох;</p> <p>34.1.7. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар болон хөдөлмөрийн нөхцөлийг дордуулсан, ажилтны эрүүл мэнд, амь насыг хамгаалах үүргээ биелүүлэхгүй байгаа албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх саналаа холбогдох байгууллагад тавих.</p>
8	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль	2009.07.16	<p>5.2. Байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг орон нутгийн удирдлага болон нутгийн иргэдийн олон нийтийн хяналт дор 2 хүртэл жилийн хугацаанд хийж дуусгана.</p> <p>5.3. Энэ хуулийн 5.2-т заасан олон нийтийн хяналтыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгаль орчныг хамгаалах зорилго, чиглэл бүхий төрийн бус байгууллагуудад гэрээний үндсэн дээр хариуцуулж болно.</p>
9	Цөмийн энергийн тухай хууль	2009.07.16	<p>49 дүгээр зүйл. Цөмийн энергийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих олон нийтийн хяналт</p> <p>49.1. Цөмийн энергийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих олон нийтийн хяналтыг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд иргэн, хуулийн этгээд хэрэгжүүлнэ.</p>
10	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль	2011.02.02	<p>22.1. Жендерийн эрх тэгш байдлыг хангахад олон нийтийн байгууллага дараах оролцоотой байна:</p> <p>22.1.1. жендерийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомж, төрийн бодлого, бусад шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавихад оролцох, иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах;</p>

			<p>22.1.2. төрийн байгууллагаас жендерийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой мэдээлэл, санхүү, арга зүйн болон бусад дэмжлэг авах;</p> <p>22.1.3. жендерийн эрх тэгш байдлын талаар саналаа илэрхийлэх.</p> <p>27.2. Жендерийн эрх тэгш байдлыг хангах, түүнчлэн эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааны хэрэгжилтэд үйлдвэрчний эвлэлийн болон олон нийтийн бусад байгууллага, иргэд олон нийтийн хяналт тавина.</p>
11	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль	2011.12.15	35.27. Сонгуулийн ерөнхий хороо болон тойргийн хороо сонгуулийн сурталчилгааны тэнцвэрт байдалд олон нийтийн оролцоотойгоор хяналт тавьж, энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, байгууллага, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэнэ.
12	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль	2012.01.19	<p>6.1. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөл / цаашид “Дэд зөвлөл” гэх/ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд ажиллана.</p> <p>6.2. Дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>6.3. Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс гадна хүн худалдаалахын эсрэг үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллийг оруулна.</p> <p>6.4. Дэд зөвлөлийн ажлын албаны үүргийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба гүйцэтгэнэ.</p>

13	Амьтны тухай хууль	2012.05.17	<p>21.5. Амьтны нөөцийг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллага агнуурын нөөцийг хамгаалах талаар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>21.5.1. амьтны тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, шаардлагатай тохиолдолд асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.</p>
14	Ойн тухай хууль	2012.05.17	<p>25.1. Ойн баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу ойг хамгаалах талаар дараах үйл ажиллагааг явуулж болно:</p> <p>25.1.1. ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс ойн санд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах.</p>
15	Хүнсний тухай хууль	2012.12.20	<p>14.1. Төрийн бус байгууллага хүнсний аюулгүй байдлыг хангахад дараах чиглэлээр оролцоно:</p> <p>14.1.1. хүнсний тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.</p>
16	Хог хаягдлын тухай хууль	2017.05.12	<p>13.2. Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн хяналтыг төрийн бус байгууллага, иргэдийн бүлэг, иргэн тавина.</p> <p>40.6. Үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг цуглуулж, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах, устгах, экспортлох амьдралын мөчлөгийг харуулсан схемтэй байх ба түүнийг олон нийтэд нээлттэй байлгана.</p>

17	Төрийн албаны тухай хууль	2017.12.07	<p>56 дугаар зүйл. Олон нийтийн хяналт</p> <p>56.1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ.</p> <p>56.2. Олон нийтийн хяналтын зөвлөлийг сонгон шалгаруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, Зөвлөлийн ажиллах дүрмийг төрийн албаны төв байгууллага батална.</p>
18	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль	2017.12.08	<p>9.9. Дархлаажуулалтын гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.</p> <p>28.5. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мал эмнэлгийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, худалдааны чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай үйл ажиллагаагаа уялдуулж хамтран ажиллана.</p>
19	Малын генетик нөөцийн тухай хууль	2017.12.14	<p>17.1. Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд орон тооны бус Үндэсний зөвлөлдөх хороо /цаашид "Хороо" гэх/ ажиллана.</p> <p>17.2. Энэ хуулийн 7.4-т заасан Үндэсний зохицуулагч нь Хорооны дарга байх бөгөөд Хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын төрийн болон төрийн бус байгууллага, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, үүлдэр, ашиг шимийн зөвлөл, мэргэжлийн холбоо, үүлдрийн нийгэмлэг, үйлдвэрлэгч, боловсруулах салбарын төлөөллийг оролцуулна.</p> <p>17.3. Хорооны нарийн бичгийн дарга нь малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ажилтан байна.</p> <p>17.4. Хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>

			<p>17.5. Хороо дараах чиг үүрэгтэй:</p> <p>17.5.1. бэлчээрийн уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх талаар санал боловсруулах;</p> <p>17.5.2. салбар болон салбар дундын түвшинд малын генетик нөөцийн үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах талаар чиглэл гаргах;</p> <p>17.5.3. тухайн жилд улсын хилээр нэвтрүүлэх малын генетик нөөц, нутагшуулах малын төрөл, ашиг шимийн чиглэл, тоо хэмжээний талаар зөвлөмж гаргах;</p> <p>17.5.4. малын генетик нөөцийг хамгаалах, ашиглах, судлан хөгжүүлэх болон энэ хуулийн 7.2-т заасан тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах;</p> <p>17.5.5. энэ хуулийн 8.6-д заасан үүлдэр, ашиг шимийн зөвлөлийн үйл ажиллагаанд чиглэл өгөх.</p>
20	Донорын тухай хууль	2018.01.19	<p>21 дүгээр зүйл. Цусны донорын үйлсийг сурталчлах, элсүүлэх</p> <p>21.1. Цусны донорын эгнээг өргөжүүлэх зорилгоор донорын хөдөлгөөнийг сурталчлах, элсүүлэх ажлыг Монголын улаан загалмай нийгэмлэг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулна.</p> <p>21.2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн донорын эгнээг өргөжүүлэх үйл ажиллагаа, үйлсийг сурталчлах, тэдгээрт зориулсан сургалт явуулахад цусны асуудал хариуцсан байгууллагад дэмжлэг үзүүлнэ.</p>
21	Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль	2018.11.15	<p>11.7. Албадан эмчлэх эмнэлэг өөрийн үйл ажиллагааны чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнтэй хамтран ажиллаж болно.</p> <p>21.2. Энэ хуулийн 21.1-д заасан эмч, тухайн засаг захиргааны нэгжийн нийгмийн ажилтан хариуцан бататгах эмчилгээнд хамрагдаж байгаа хүнд зориулан нийгэм, хамт олонд түшиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг түүний гэр бүл, тухайн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран явуулж болно.</p>

22	Татварын ерөнхий хууль	2019.03.22	<p>46.5. Маргаан таслах зөвлөлийг тухайн байгууллагын удирдлагатай зөвшилцсөний үндсэн дээр дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулна:</p> <p>46.5.1. аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнд нутгийн захиргааны байгууллага, татварын албаны төлөөлөл, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл;</p> <p>46.5.2. татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнд татварын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, татварын албаны төлөөлөл, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл.</p>
23	Хэмжил зүйн тухай хууль	2019.05.09	<p>18.1. Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд хэмжил зүйг хөгжүүлэх, хэмжил зүйн бодлогыг хэрэгжүүлэх, салбар хоорондын уялдааг хангах үүрэг бүхий орон тооны бус Хэмжил зүйн зөвлөл / цаашид "Зөвлөл" гэх/ төр, шинжлэх ухааны болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй ажиллана.</p> <p>18.2. Зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Засгийн газар батална;</p> <p>18.3. Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга Зөвлөлийн хуралдааныг даргална.</p> <p>18.4.Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>18.4.1. хэмжил зүйн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийн явцыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;</p> <p>18.4.2. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлаар болон шийдвэрийн биелэлтийн талаарх судалгаа, мэдээг холбогдох байгууллага, албан тушаалтнаар гаргуулах;</p> <p>18.4.3. хэмжил зүйн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар чиглэл, зөвлөмж өгөх;</p>

			<p>18.4.4. энэ хуулийн 13.4-т заасан тайланг хэлэлцэх;</p> <p>18.4.5. Зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих.</p>
24	<p>Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль</p>	2019.06.06	<p>10.3. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, дүгнэхэд эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангана.</p> <p>16.2. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний талаарх энэ хуульд заасан төрийн зарим чиг үүргийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төрийн бус байгууллагад шилжүүлж болно.</p> <p>17.1. Жижиг, дунд үйлдвэрийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхлэн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>17.1.10. жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох.</p>
25	<p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль</p>	2019.06.06	<p>15.1. Зохицуулах зөвлөл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд дараах хэлбэрээр уялдуулан зохицуулна:</p> <p>15.1.2. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бодлогын нэгдмэл байдлыг хангах.</p> <p>17.1. Зохицуулах зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>17.1.3. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;</p>

			17.1.8. холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт, эрдэмтдийн төлөөллийг оролцуулан ажлын хэсэг байгуулан ажиллуулах.
26	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль	2019.11.13	25.5. Энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.3.18, 5.3.19-д заасан тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хороо болон хяналтын хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулах ба тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавихад олон нийтийн оролцоог хангана.
27	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль	2019.12.30	58.2. Төрийн аудитын дээд байгууллага сонгуулийн зардлын тайлангийн талаар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ: 58.2.1. нам, эвсэл, нэр дэвшигчийн авсан хандив, санхүүжилт, зарцуулалтад дангаараа болон төрийн бусад байгууллагатай хамтран хяналт тавих. 67.1 ..., Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн бус байгууллага нэг санал авах байранд хоёр хүртэл сонгуулийн ажиглагч /цаашид "ажиглагч" гэх/-ийг томилж ажиллуулах эрхтэй. 67.13. Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилт бүхий дүрэмтэй, улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллага нь сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх эрхтэй.
28	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль	2020.01.23	30 дугаар зүйл. Иргэний нийгмийн зөвлөл 30.1. Комисс үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Иргэний нийгмийн зөвлөлтэй байна. 30.2. Иргэний нийгмийн зөвлөлийн олон талт төлөөллийг хангахдаа хүний эрхийн асуудал эрхэлсэн ашгийн төлөө бус хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн багш, судлаачийг оролцуулна. 30.3. Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн дараах шаардлагыг хангасан байна:

			<p>30.3.1. хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн гишүүн байх, эсхүл эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн багш, судлаач байх;</p> <p>30.3.2. хүний эрхийн чиглэлээр сүүлийн гурван жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан, эсхүл судалгаа, шинжилгээний ажил эрхэлсэн байх;</p> <p>30.3.3. улс төрийн намын харьяалалгүй байх, эсхүл түдгэлзсэн тухай шийдвэр гарсан байх.</p> <p>30.4. Иргэний нийгмийн зөвлөлийн дүрмийг Комиссын хуралдаанаар баталж, мөрдүүлнэ.</p>
29	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	2020.04.24	<p>251.1. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Орон тооны бус зөвлөл хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана.</p> <p>251.2. Зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ахалж, бүрэлдэхүүнд нь санхүү, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий байгууллага, прокурор, шүүх, холбогдох бусад төрийн байгууллагын төлөөллөөс бүрдүүлж ажиллана.</p> <p>251.3. Энэ хуулийн 251.2-т заасан Зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж болно.</p> <p>251.4. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>251.5. Зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>251.5.1. гэрч, хохирогчийг хамгаалах салбар дундын ажлыг уялдуулан зохицуулах;</p> <p>251.5.2. гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг шийдвэрлэх талаар санал боловсруулах, хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;</p>

			<p>251.5.3. холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн бус байгууллагад зөвлөмж өгөх;</p> <p>251.5.4. гэрч, хохирогчийг хамгаалах байгууллага, албадын алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>251.5.5. иргэд, олон нийтэд хууль тогтоомжийг сурталчлах.</p>
30	Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль	2020.04.29	<p>7.1.6. цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр ажиллаж байгаа байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангах, харилцан мэдээлэл солилцох, уг үйл ажиллагаанд төрийн бусад байгууллагыг татан оролцуулах журмыг Улсын онцгой комиссын санал болгосноор батлах /Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/.</p> <p>11.6. Хүний эрхийн Үндэсний Комисс Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасан чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд энэ хуульд заасан арга хэмжээнд хяналт тавина /Энэ хэсгийн дугаарт 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/.</p> <p>11.7. Энэ хуулийн 11.6-д заасан хяналт тавих үйл ажиллагаанд төрийн бусад байгууллагууд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана /Энэ хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн/.</p>
31	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль	2020.12.24	<p>63.1 ..., Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн бус байгууллага нэг санал авах байранд хоёр хүртэл сонгуулийн ажиглагч /цаашид "ажиглагч" гэх/-ийг томилж ажиллуулах эрхтэй бөгөөд энэ эрхийг хууль бусаар хязгаарлахыг хориглоно.</p> <p>63.13. Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилт бүхий дүрэмтэй, улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй, хараат бус төрийн бус байгууллага нь сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх эрхтэй.</p>

32	Музейн тухай хууль	2021.01.29	5.7. Музейн дүрэмд заасан бол музейн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий олон нийтийн зөвлөл ажиллаж болно. Зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 18.2. Музейн үйл ажиллагаанд Олон нийтийн зөвлөл хяналт тавьж болно.
-----------	--------------------	------------	--

Хавсралт 2. Иргэний нийгмийн зөвлөлийн дүрмийн загвар төсөл

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2021 оны ... дугаар сарын ... –ны өдрийн ... дугаар тогтоолын хавсралт

ИРГЭНИЙ НИЙГМИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Иргэний нийгмийн зөвлөлийн (цаашид “Зөвлөл” гэх) үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү дүрмээр зохицуулаагүй бусад асуудлыг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос (цаашид “Комисс” гэх) тухай бүр холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

1.3. Зөвлөлөөс дараах дэмжлэгийг Комисст хариу төлбөргүй үзүүлнэ:

1.3.1. хүний эрхийн асуудлаар шинжээчийн дүгнэлт гаргах;

1.3.2. хүний эрхийн зөрчлөөс сэрэмжлүүлэх;

1.3.3. хүний эрхийг хамгаалах, дэмжихтэй холбоотой баримт бичгүүдэд мониторинг хийх, тэдгээр баримт бичгийг боловсронгуй болгох санал гаргах, түүнийг хэрэгжүүлэхэд туслах;

1.3.4. Комиссын зорилго, чиг үүрэг, гомдол шийдвэрлэх талаарх ойлголт, мэдлэгийг түгээх сүлжээ бий болгох замаар хүний эрхийг хамгаалах, дэмжих асуудлаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхэд туслах;

1.3.4. Комиссыг чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай мэдээллээр хангах;

1.3.5. Комисст гомдол гаргах асуудлаар хохирогчид дэмжлэг үзүүлэх.

1.4. Зөвлөл нь хүний эрхийн асуудлаар Комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх эрх бүхий хүний эрхийн асуудлаар мэргэшсэн шинжээчдээс бүрдэх бүтэц байна.

Хоёр. Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаанд Иргэний нийгмийн зөвлөл дэмжлэг үзүүлэх зарчим

2.1. Зөвлөлөөс Комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд дараах зарчмыг баримтална:

2.1.1. хүний эрх, эрх чөлөөг дээдлэх;

2.1.2. хараат бус байх;

2.1.3. хичээл зүтгэл гаргах;

2.1.4. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Комиссын чиг үүргийн хүрээнд дэмжлэг үзүүлэх.

2.2. Комисс Зөвлөлөөс дэмжлэг хүсэхдээ дараах зарчмыг баримтална:

2.2.1 хүртээмжтэй байх;

2.2.2. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Комиссын чиг үүргийн хүрээнд дэмжлэг авах;

2.2.3. Зөвлөлийн гишүүдэд тэгш хандах;

2.2.4. Зөвлөлийн гишүүдийн мэргэшсэн салбар, туршлагатай нь шууд хамаарах асуудлаар дэмжлэг хүсэх.

2.3. Зөвлөлийн гишүүн нь хүний эрхийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаа явуулахгүй болсон, хүний эрх, эрх чөлөөнд харшлах үйл ажиллагаа явуулсан, хүний эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтнаас хандив, урамшуулал авсан бол энэ талаар Зөвлөл нээлттэй хэлэлцэж, энэ тухай Комисст мэдэгдэнэ.

2.4. Зөвлөлийн гишүүнээр сонгогдох этгээд хүний эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр олон нийтэд болон тухайн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн байх бөгөөд Комиссоос сонгон шалгаруулалтын үндсэн дээр холбогдох баримт бичгийг үндэслэн Зөвлөлийн гишүүнийг томилно.

2.5. Зөвлөлийн гишүүнээр сонгогдох этгээд нь тухайлан итгэмжлэл олгосноос бусад тохиолдолд төрийн бус байгууллага, бусад байгууллагыг төлөөлөхгүй, зөвхөн Зөвлөлийн үйл ажиллагаанд бие даасан шинжээчийн хувиар оролцоно.

2.6. Зөвлөлийн гишүүнийг томилох, түдгэлзүүлэх, чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг үндэслэн Комиссын хуралдаанаар шийдвэрлэх бөгөөд тийнхүү түдгэлзүүлэх, чөлөөлөх шийдвэр гаргахаас өмнө Зөвлөлийн гишүүн эс зөвшөөрч хариу тайлбар гаргах боломжтой байна.

Гурав. Хүний эрхийн Үндэсний Комисс ба Иргэний нийгмийн зөвлөл хоорондын үйл ажиллагаа

3.1. Комиссоос дэмжлэг шаардлагатай үйл ажиллагааны талаар Зөвлөлд буюу түүний гишүүнд тухай бүр мэдэгдэнэ.

3.2. Зөвлөлөөс өөрийн санаачилгаар Комисст дэмжлэг үзүүлэх тодорхой саналаа Зөвлөл хариуцсан Комиссын гишүүн буюу Комиссын Тамгын газрын /цаашид “Тамгын газар” гэх/ даргаар дамжуулан Комисст мэдэгдэж болно.

3.3. Зөвлөл нь Комисст энэ дүрмийн 1.3-т заасан дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн дараах үйл ажиллагаа явуулна:

3.3.1. Комиссын хуралдаанд оролцох;

3.3.2. бичгээр мэдэгдэл гаргах;

3.3.3. хуралдаанд амаар танилцуулга хийх;

3.3.4. Комиссын хүсэлтээр тухайлсан асуудлаар судалгаа хийх, хянан шалгах, баримт бичиг бэлтгэх;

3.3.5. Комиссоос зохион байгуулах хурал, бусад үйл ажиллагаанд оролцох.

3.4. Зөвлөлөөс түүнийг төлөөлөх гишүүнийг Комиссын нээлттэй хуралдаанд ажиглагчаар оролцуулж болно. Зөвлөлөөс төлөөлөгчөөр ажиллуулах гишүүн нь Комиссын тухайн хуралдаанд хэлэлцэж буй асуудлаар мэргэшсэн, туршлагатай гишүүн байвал зохино.

3.5. Комиссын үйл ажиллагаанд хамаарах асуудлаар Зөвлөл буюу тухайн асуудлаар мэргэшсэн Зөвлөлийн гишүүнээс бичгээр мэдэгдэл гаргаж болно. Тухайн мэдэгдлийг урьд гаргасан, түүнд дурдсан асуудлыг шийдвэрлэснээс бусад тохиолдолд түүнийг Тамгын газраас Комиссын гишүүдэд хүргүүлнэ.

3.6. Бичгээр мэдэгдэл гаргах, түүнийг хүлээн авах, шийдвэрлэхэд дараах журмыг баримтална:

3.6.1. мэдэгдлийг төрийн албан ёсны хэлээр үйлдсэн байна;

3.6.2. мэдэгдлийг Тамгын газар хүлээн авч, Комиссын гишүүд түүнтэй танилцах, Зөвлөлийн гишүүдтэй зөвлөлдөх хангалттай хугацааны өмнө хүргүүлнэ;

3.6.3. мэдэгдлийг Тамгын газар хүлээн авч, Комиссын гишүүдэд хүргүүлэхийн өмнө Зөвлөлөөс нэмэлт тайлбар гаргах эсэхийг тодруулна;

3.6.4.мэдэгдлийг 2000 үгээс хэтрүүлээгүй байна. Мэдэгдэл 2000 үгээс хэтрэх тохиолдолд тухайн мэдэгдлийн хураангуйг үйлдэж, дэлгэрэнгүй бичвэрийг хавсаргана. Энэ нь Комиссоос хүссэний дагуу дэлгэрэнгүй мэдэгдэл гаргахыг хязгаарлахгүй.

3.7.Зөвлөл хариуцсан Комиссын гишүүний буюу Комиссын хуралдааны даргалагчийн хүсэлтээр Зөвлөлийн гишүүн Комиссын хуралдаанд амаар танилцуулга хийж болно. Тийнхүү амаар танилцуулга хийх Зөвлөлийн гишүүн нь Комисст хандаж Комиссоос баталсан сэдвийн хүрээнд нэг удаа мэдэгдэл гаргаж болно.

3.8. Комиссын хүсэлтээр хүний эрх, эрх чөлөөнд хамаарах тухайлсан асуудлаар мэргэшсэн Зөвлөлийн гишүүн буюу гишүүд хамтран Комисст зориулсан судалгаа хийх, хянан шалгах, баримт бичиг бэлтгэх үүргийг хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд санхүүжилтийг тодорхой журмын дагуу шийдвэрлэнэ. Баримт бичиг бэлтгэхэд энэ дүрмийн 3.6.4-т заасан үгийн тоо хамаарахгүй.

3.9.Зөвлөл, түүний гишүүдийн хувьд Комиссоос зохион байгуулах хурлын бэлтгэл болон үндсэн үйл ажиллагаанд Комиссын урилгаар юм уу өөрсдийн саналаар оролцож болно. Тамгын газраас Зөвлөлийн гишүүдийг хуралд оролцуулах ажлыг зохион байгуулна. Комиссоос зохион байгуулах хуралд илтгэл хэлэлцүүлэх, мэдэгдэл хийх эсэх асуудлыг Зөвлөлийн гишүүдийн саналын үндсэн дээр хурлын сэдэв, хөтөлбөр, оролцогчдын тоо зэрэг нөхцөл байдлыг харгалзаж Комиссын дарга шийдвэрлэнэ.

3.10. Энэ дүрмийн 3.3-т заасан үйл ажиллагааны хүрээнд Зөвлөл, түүний гишүүнээс гаргасан дүгнэлт, саналыг Комисс заавал харгалзан үзэж, энэ тухай холбогдох баримт бичиг, шийдвэрт тусгана.

Дөрөв. Иргэний нийгмийн зөвлөлийн дотоод үйл ажиллагаа

4.1.Зөвлөлийн дотоод үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь ээлжит болон ээлжит бус хурал байна. Хурлаас гарах шийдвэр, мэдээллийг бичгээр үйлдэх бөгөөд Комисст хандсан шийдвэр нь зөвлөмж хэлбэртэй байна.

4.2. Зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

4.2.1.Зөвлөлийн гишүүдийн ажил, үүргийн хуваарь;

4.2.2. Зөвлөлөөс Комисст шууд болон Комиссоор дамжуулан бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх дүгнэлт, санал;

4.2.3. энэ дүрмийн 3.3-т заасан үйл ажиллагаанд оролцох асуудал;

4.2.4. Зөвлөлийн даргыг сонгож, томилуулах асуудал;

4.2.5. Зөвлөлийн үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө;

4.2.6. Зөвлөлийн гишүүдийн санаачилсан бусад асуудал.

4.3. Зөвлөлийн ээлжит хурлыг улиралд нэгээс доошгүй удаа Зөвлөлийн даргын зарласнаар, ээлжит бус хурлыг Комиссын даргын хүсэлтээр болон Зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар зарлан хуралдуулна.

4.4. Тамгын газраас Зөвлөлийн хурлыг зохион байгуулахтай холбоотой бүх талын дэмжлэг үзүүлнэ.

Тав. Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн

5.1. Зөвлөл нь хүний эрхийн асуудал эрхэлсэн ашгийн төлөө бус хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн багш, судлаачийг оролцуулсан олон талт төлөөлөл бүхий 15-аас доошгүй тооны гишүүнтэй байна. Зөвлөлийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Комиссын хуралдаанаас 6 жилийн хугацаагаар томилно.

5.2. Зөвлөлийн гишүүн нь улс төрийн намын харьяалалгүй байх, эсхүл Зөвлөлийн гишүүнээр нэр дэвшихээс өмнө холбогдох шийдвэрийн дагуу улс төрийн намын харьяаллаас түдгэлзсэн байна.

5.3. Зөвлөлийн гишүүнээр нэр дэвших этгээд дараах нөхцөлийн аль нэгийг хангасан байна:

5.3.1. хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн гишүүн байх;

5.3.2. эрдэм шинжилгээний байгууллагын судлаач байх;

5.3.3. их, дээд сургуулийн багш байх;

5.3.4. хүний эрхийн чиглэлээр сүүлийн гурван жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан, эсхүл судалгаа, шинжилгээний ажил эрхэлсэн байх.

5.4. Комиссын Тамгын газраас Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

5.5. Энэ дүрмийн 5.2, 5.3-т заасан шаардлагыг хангасан иргэн сонгон шалгаруулалтыг нийтэд мэдээлснээс хойш 14 хоногийн дотор нэр дэвших тухай хүсэлтээ Комиссын Тамгын газарт хүргүүлнэ.

5.6. Комиссоос ажлын хэсэг байгуулж, 14 хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулна. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад хамгийн өндөр оноо авсан иргэдээс сул орон тоо гарсан гишүүний тоогоор нэр дэвшүүлж, Комиссын хуралдаанаар хэлэлцүүлэх санал гаргана.

5.7. Комисс долоо хоногийн дотор хэлэлцэж, Зөвлөлийн гишүүнээр томилох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

5.8. Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг Комиссын гишүүдийн олонх нь дэмжээгүй бол 14 хоногийн дотор энэ дүрэмд заасан журмын дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулж, хамгийн өндөр оноо авсан иргэдээс дарааллын зарчмаар нэр дэвшүүлнэ.

5.9. Зөвлөлийн гишүүнийг томилохдоо жендерийн тэгш байдал, хүний эрхийн салбарыг төлөөлөх байдал, олон ургалч байдлыг харгалзан үзнэ.

5.10. Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохоос өмнө энэ дүрмийн 5.2, 5.3-т заасан шаардлагыг хангахгүй болсон, хүний эрх, эрх чөлөөний эсрэг ноцтой зөрчил гаргасан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг Комиссоос чөлөөлж, энэ дүрэмд заасны дагуу тухай бүр нөхөн томилно.

5.11. Зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулахтай холбоотой бусад асуудлыг энэ дүрэмд нийцүүлэн Комиссоос шийдвэрлэнэ.

5.12. Зөвлөлийн гишүүдэд цалин хөлс, урамшуулал олгохгүй бөгөөд зөвхөн үйл ажиллагааны зардал олгоно.

Зургаа. Иргэний нийгмийн зөвлөлийн тайлан

6.1. Зөвлөлөөс жил бүр үйл ажиллагааны тайлан гаргаж тухайн оны 1 дүгээр сард багтаан Тамгын газраар нь дамжуулан Комиссын гишүүдэд хүргүүлэх бөгөөд Зөвлөлийн тайланг олон нийтэд мэдээлнэ.

6.2. Энэ дүрмийн 6.1-д заасан тайланд Зөвлөлийн гишүүн бүрийн тайланг хавсаргах бөгөөд Зөвлөлийн гишүүн тийнхүү тайлан гаргаж өгөх үүргээ удаа дараа биелүүлээгүй буюу 1 сараас дээш хугацаагаар хожимдуулсан нь энэ

дүрмийн 5.10-т заасны дагуу чөлөөлөх эсэх асуудлыг хэлэлцэх үндэслэл болно.

Долоо. Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүний үйл ажиллагаа

7.1. Энэ дүрмийн 3.3-т заасан үйл ажиллагааны хүрээнд Зөвлөлийн гишүүн дараах үйл ажиллагаа явуулна:

7.1.1. Комиссын ажилтан, мэргэжилтнүүдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

7.1.2. Комиссоос зохион байгуулж буй нөлөөлөл, сурталчилгаа, хүний эрхийн боловсрол олгох, судалгаа, хяналт шалгалт болон бодлогын шинжтэй бусад ажилд Комиссын гишүүдийн хуралдаанаас зөвшөөрсөн хэмжээнд оролцох, дэмжлэг үзүүлэх;

7.1.3. Комиссоос боловсруулсан хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, дэмжихтэй холбогдсон бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны хөтөлбөр, тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд санал өгөх;

7.1.4. Комиссын явуулж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг тухай бүр авах;

7.1.5. Комисс болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааны чиглэл, үйл ажиллагааны талаар санал гаргах;

7.1.6. Үйл ажиллагааныхаа үр дүнгийн талаар улирал бүр Комиссоос зохион байгуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын уулзалтад тайлагнах;

7.1.7. Хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон зайлшгүй судалж, арга хэмжээ авбал зохих асуудлын талаар Комисст тогтмол мэдээлэл хүргүүлж, санал өгөх.

7.2. Энэ дүрмийн 7.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс бусад үед Зөвлөлийн гишүүнд дараах зүйлийг хориглоно:

7.2.1. Хувийн болон байгууллагынхаа үйл ажиллагаанд Комиссын нэр, таних тэмдэг бүхий Зөвлөлийн гишүүний үнэмлэхээ ашиглах;

7.2.2. Комиссын үйл ажиллагааны талаар батлагдаагүй, тодорхой бус мэдээллийг олон нийтэд түгээх;

7.2.3. Зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр Зөвлөлийн байр суурийг олон нийтэд мэдээлэх;

7.2.4. Зөвлөлийн үйл ажиллагаа, шийдвэрийг аливаа сонгууль болон бусад зорилгоор улс төрийн хэлбэрээр ашиглах

Ном зүй

A. Монгол хэлээр:

I. Эрх зүйн акт

1. Монгол Улсын олон улсын гэрээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм
2. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай (шинэчилсэн найруулга) хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2020, №08.
3. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2000, №48.
4. Улсын Их Хурлын 2003 оны 41 дугаар тогтоолын хавсралт, “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”
5. Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралт, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”
6. Хүний эрхийн Үндэсний комиссын даргын 2017.12.19-ний өдрийн “Журам батлах тухай” Б/24 дүгээр тушаалын хавсралт, “Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын орон тооны бус зөвлөхийн ажиллах журам”

II. Танилцуулга, санал, дүгнэлт

1. Монгол Улсын Засгийн газраас 2000.11.10-ны өдөр Улсын Их Хуралд хүргүүлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн төслийн талаарх танилцуулга
2. Монгол Улсын Засгийн газраас 2000.11.10-ны өдөр Улсын Их Хуралд хүргүүлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн төслийн талаарх танилцуулгын хавсралт, Яамдаас ирсэн саналын товчоон
3. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, 2000.11.21.
4. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Хууль зүйн байнгын хорооны танилцуулга, 2000.11.28.
5. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, 2019.10.22.
6. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны

хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга, 2020.01.08, <http://forum.parliament.mn/projects/10695>

III. Тэмдэглэл

1. Улсын Их Хурлын 2000 оны намрын чуулганы 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны протокол, Дугаар 14, 51-52 дахь тал.
2. Улсын Их Хурлын 2000 оны намрын чуулганы 11 дүгээр сарын 28-ны өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдааны протокол, Дугаар 14, 13-14 дэх тал.
3. Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы Хууль зүйн байнгын хорооны 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр (Мягмар гараг)-ийн хуралдааны тэмдэглэл, <http://parliament.mn/files/85628>
4. Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл (Лхагва гараг, 2020.01.15).
5. Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл (Пүрэв гараг, 2019.10.24), <http://parliament.mn/n/35ky>
6. Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл (Пүрэв гараг, 2020.01.16).
7. Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл (Пүрэв гараг, 2020.01.23), <http://parliament.mn/n/ixmy>

IV. Тайлан, мэдээлэл

1. Г.Уранцоож, “Иргэний нийгмийн байгууллага ба хүний эрхийн үндэсний байгууллагын хамтын ажиллагааны үр нөлөө, түүнийг сайжруулах нь: олон улсын туршлага”, “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл, 2016/01 (47).
2. Ж.Бямбадорж, “Хүний эрхийн төлөө хамтдаа зүтгэсэн 15 жил”, “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл, 2016/01.
3. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2013 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, 2013.07.10.
4. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2014 оны үйл ажиллагааны тайлан
5. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2015 оны үйл ажиллагааны тайлан
6. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2016 оны үйл ажиллагааны тайлан

7. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2017 оны үйл ажиллагааны тайлан
8. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2018 оны үйл ажиллагааны тайлан
9. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2019 оны үйл ажиллагааны тайлан
10. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2020 оны үйл ажиллагааны тайлан, 2021.01.05.
11. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын стратеги төлөвлөгөө (2015-2020 он)
12. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны тайлан, 2018.
13. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зардлын тооцооны тайлан, 2018.
14. Монголын хүний эрхийн ТББ-уудын форумын 2019.10.03-нд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд хүргүүлсэн мэдээлэл

Б. Гадаад хэлээр:

1. Principles relating to the Status of National Institutions (The Paris Principles), Adopted by General Assembly resolution 48/134 of 20 December, 1993.
2. The Economic and Social Council, UN. Resolution 1996/31, Consultative relationship between the United Nations and non-governmental organizations, 49th plenary meeting, 25 July 1996.
3. ECOCOC resolution 2008/4 on "Measures to improve the quadrennial reporting procedures."
4. Secretary-General's report to the General Assembly on the role of the Ombudsman, mediator and other national human rights institutions in the promotion and protection of human rights, A/75/224
5. Secretary-General's report to the General Assembly on national institutions for the promotion and protection of human rights, A/74/226
6. Secretary-General's report to the Human Rights Council on national institutions for the promotion and protection of human rights, A/HRC/39/20
7. Recommendation CM/Rec(2021)1 of the Committee of Ministers to member States on the development and strengthening of effective, pluralist and independent national human rights institutions (Adopted by the Committee of Ministers on 31 March 2021 at the 1400th meeting of the Ministers' Deputies)
8. United Nations, Working with ECOSOC - A NGOs Guide to an Consultative Status, New York, 2018.

9. UNDP-OHCHR Toolkit for collaboration with National Human Rights Institutions, December 2010.
10. Consultative Status with ECOSOC and other accreditations
11. Global Alliance of National Human Rights Institutions (GANHRI), Members
12. Global Principles for the Capacity Assessment of National Human Rights Institutions, UNDP, 2016.
13. Приложение №1 к распоряжению Уполномоченного по правам человека в городе Москве от 14 ноября, 2014 года, №52.
14. Федеральным конституционным закон от 26 февраля 1997 года, №1-ФКЗ «Об Уполномоченном по правам человека в Российской Федерации»
15. Asian Forum for Human Rights and Development, Cooperation and Engagement between National Human Rights Institutions (NHRIs) and Civil Society, 6 August, 2018.
16. Assessing the Effectiveness of National Human Rights Institutions, International Council on Human Rights Policy, 2005.
17. Austrian Ombudsman Board - The Human Rights Advisory Council
18. Commonwealth Human Rights Initiative. Partnership for Human Rights: Civil Society and National Human Rights Institutions, The International Journal of Not-for-Profit Law, Volume 13, Issue 4, December 2011.
19. High Commissioner for Human Rights in the Russian Federation - Expert Council
20. Human Rights Commission of Sri Lanka - Thematic Sub Committees
21. National Human Rights Commission of Korea, National Human Rights Commission Act
22. Organization chart – Human Rights Commission of Malaysia (SUHAKAM)
23. Renshaw, Catherine (2012), National Human Rights Institutions and Civil Society Organizations: New Dynamics of Engagement at Domestic, Regional and International Levels. Global Governance, 18, pp.299-316. 10.1163/19426720-01803004.
24. The Federal Law on the Austrian Ombudsman Board (Volksanwaltschaftsgesetz 1982 - VolksanwG).
25. Summary of Stakeholders' submissions on Mongolia, Report of the Office of the United Nations High Commissioner for Human Rights - A/HRC/WG.6/36/MNG/3



“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.
Утас: 319658, 70140459
Вэб хаяг: www.munkhiin-useg.mn

ISBN 9919-9742-5-0



9 789919 974251